



БАРИЛГА ХОТ
БАЙГУУЛАЛТЫН
ЯАМ



ОРХОНЫ ХӨНДИЙД ХОТ БАЙГУУЛАХ УРЬДЧИЛСАН ТАНДАН СУДАЛГАА

Улаанбаатар хот
2022 он

Агуулга

ҮНДЭСЛЭЛ	3
Судалгааны хамрах хүрээ	4
БҮЛЭГ 1. ОДООГИЙН БАЙДАЛ	5
1.1. Байгаль газарзүйн ерөнхий байдал	5
1.3. Газар чичирхийллийн үнэлгээ	18
1.4. Инженер геологи.....	21
1.5. Газар ашиглалтын байдал	28
1.6. Нийгэм эдийн засгийн судалгаа	32
1.6.1. Засаг захиргаа, бүлэг суурингийн тогтолцоо	35
1.6.2. Аж үйлдвэр, үйлчилгээ, хөдөлмөрийн зах зээл	36
1.6.3. Хөдөө аж ахуй, газар тариалан	39
1.6.4. Уул уурхай	40
1.6.5. Аялал жуулчлал	40
1.7.Нийгмийн дэд бүтэц.....	42
1.7.1.Ерөнхий боловсролын сургууль.....	42
1.7.2.Сургуулийн өмнөх боловсрол	43
1.7.3. Эрүүл мэндийн байгууллага	44
1.8. Зам тээвэр	45
1.9. Инженерийн дэд бүтэц	47
БҮЛЭГ 2. НУТАГ ДЭВСГЭРИЙН ХОТ БАЙГУУЛАЛТЫН ИЖ БҮРЭН ҮНЭЛГЭЭ ...	51
ДҮГНЭЛТ	53
АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ	54

СУДАЛГААНЫ ҮНДЭСЛЭЛ

Орхоны хөндийд шинэ хот байгуулах талаар урьдчилсан тандан судалгааг Алсын хараа-2050, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр 2020-2024, Барилга, хот байгуулалтын яамны 2021 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Барилга, хот байгуулалтын яамны 3/909 тоот албан бичигт үндэслэн “Барилгын хөгжлийн төв” ТӨААТҮГ-аас “Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл” боловсруулах ажлын хүрээнд боловсруулав.

Хууль эрхзүйн орчин

Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 2 хэсэгт эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй гэж заасан байдаг.

Судалгааны нутаг дэвсгэрт UNESCO-ийн Дэлхийн Өвийн Хороо Орхоны Хөндийн Соёлын Дурсгалт Газрыг Дэлхийн соёлын өвийн II, III болон IV шалгуур үзүүлэлтүүдийг хангаж байна гэж 2004 онд Дэлхийн соёлын өвөөр бүртгэсэн газар байрладаг.

Монгол Улсын Их Хурлын 2003 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн Бүсийн тулгуур төв хотыг тогтоох тухай 01 дүгээр тогтоолд заасны дагуу Хархорин хот нь Хангай бүсийн хоёр тулгуур төв хотын нэг гэсэн заалт байдаг.

“Бүсийн тулгуур төв хотыг тогтоох тухай” Улсын Их Хурлын 2003 оны 1 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газрын 2003 оны 6 дугаар сарын 4-ний өдрийн 136 дугаар захирамж гарсан.


Монгол Улсын Засгийн газрын 2006 оны 57 дугаар тогтоолоор батлагдсан Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 3.7.14-т “Хархорин, Эрдэнэ зуу орчмыг хот төлөвлөлтийн орчин үеийн аргачлалаар жуулчдын төв хот болгон хөгжүүлэх хөтөлбөр, хотын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг боловсруулна” гэсэн заалт бий.

“АЛСЫН ХАРАА-2050” МОНГОЛ УЛСЫН УРТ ХУГАЦААНЫ ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД 2021-2030 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 8.2.8.Орхоны хөндийд шинэ нийслэлийн байршлыг сонгож, техник, эдийн засгийн үндэслэл, хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулж, бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлнэ” гэсэн заалт байдаг.

Судалгааны хамрах хүрээ

Орхоны хөндийд байрлах Архангай аймгийн Өгийнуур, Өлзийт, Хотонт, Хашаат, Булган аймгийн Могод, Гурванбулаг, Сайхан, Өвөрхангай аймгийн Хархорин гэсэн 8 сумын 46 багийн 15926 км² нутаг дэвсгэрийг хамруулав.

Зураг 1. Судалгааны хамрах хүрээ



Тайлбар: Судалгааны хүрээнд боловсруулав

БҮЛЭГ 1. ОДООГИЙН БАЙДАЛ


1.1. Байгаль газарзүйн ерөнхий байдал

Орхоны хөндий нь Хангайн нурууны зүүн талд далайн төвшнөөс дээш дунджаар 1350-2300 метрийн өндөрт Өвөрхангай аймгийн Хархорин, Архангай аймгийн Өгийнуур, Өлзийт, Хашаат, Хотонт сумдын нутгийг дамнан урсдаг Орхон голыг даган тэдгээрийн нутаг дэвсгэрийг эзлэн Улаанбаатар хотоос 360 км, Монгол улсын нутаг дэвсгэрийн төв цэгээс 100 км, Нийслэлийн анхны шав тавьсан газар Ширээт цагаан нуураас 100 орчим км-ийн зайд оршдог.

Усны нөөц, ашиглалт. Орхоны хөндийн бүс нутагт багтах 3 аймгийн 8 сум нь ус хагалбарын Хойд Мөсөн далайн ай савд багтана. Хойд Мөсөн далайн ай савд Шишхид, Сэлэнгэ мөрөн, Орхон, Туул, Хараа, Ерөө, Эг, Дэлгэрмөрөн, Чулуут, Идэр, Хануй, Хүнүй гэсэн Монгол орны томоохон голууд багтах бөгөөд Хөвсгөл, Өгийнуур, Сангийн далай, Тэрхийн цагаан нуур, Доод цагаан нуур зэрэг 20 км²-аас дээш талбайтай нуурууд байна. Монгол орны гадаргын усны нөөц 34.6 км³ бөгөөд судалгааны бүсэд багтах Архангай, Булган, Өвөрхангай аймгийн нутаг нийлээд 5.14 км³ гадаргын усны нөөцтэй байгаа нь улсын нийт гадаргын усны нөөцийн 14.9 хувийг эзэлж байна. Гадаргын усны ашиглах боломжит нөөцийн 27.4 хувийг эзэлж байгаа нь бусад бүс, аймгуудаас өндөр үзүүлэлттэй байна. Тус бүсэд багтах голуудын тэжээлийн 38-69 хувийг хур борооны ус бүрдүүлдэг.

Архангай аймгийн Хашаат сум нь Туул голын сав газарт, Архангай аймгийн Хотонт, Өгийнуур, Өлзийт, Булган аймгийн Могод, Сайхан, Гурванбулаг, Өвөрхангай аймгийн Хархорин сум Орхон голын сав газарт багтана. Орхон голын сав газарт Орхон, Урд Тамир, Хойд Тамир, Жарантай, Бургалтай, Зуунмод зэрэг голууд, Туул голын сав дагуу Туул, Тарнайн гол, Тэрэлж голууд хамрагдана. Тус бүс нутагт багтах сумдын төвөөр Орхон гол, Архангай аймгийн Хотонт сумын төвөөр Цагаан сүмийн /Жарантай/ гол урсах бол Архангайн Хашаат, Булган аймгийн Могод, Сайхан сумдын төв гадаргын ус байхгүй байна.

Зураг 2. Ус хангамжийн үнэлгээ



Эх сурвалж: ХАНСХЕТ 2020, Ус хангамжийн үнэлгээ

Дээрх ус хангамжийн үнэлгээнээс харахад Архангай аймгийн Хашаат, Өвөрхангай аймгийн Гурванбулаг сум нь дунд зэргийн усны хэрэгцээтэй үйлдвэр байгуулж болох нутаг дэвсгэрт хамаарагдаж байгаа бол Архангай аймгийн Хашаат сум төв, суурин газрын ус хангамжийн батлагдсан орд ба нөөцийн хэмжээ 776.9 м³/хоног байгаа бол Өвөрхангай аймгийн Хархорин сум 7344.0 м³/хоног байна. Мөн ус хангамжийн системд холбогдсон төв, суурин газар, бохир усны цэвэрлэх байгууламжтай төв, суурин газарт усны хэрэгцээ ихтэй үйлдвэр байгуулж болох нутаг дэвсгэрт хамаарагдаж байна. Бусад 5 сумын хувьд усны хэрэгцээ ихтэй үйлдвэр байгуулж болох нутаг дэвсгэрт багтаж байна. Ус хангамжийн түвшин нэн өндөр төв, суурин газарт Өвөрхангай аймгийн Хархорин сум орж байна.

Хүснэгт 1. Төв суурин газрын ус хангамжийн батлагдсан нөөцтэй сумд

№	Аймаг	Сумын нэр	Ус хангамжийн ГДУ батлагдсан нөөц, м3 /хоног
1	Архангай	Хашаат	776.9
2	Өвөрхангай	Хархорин	7344.0

Эх сурвалж: ХАНСХЕТ 2020, Ус хангамжийн үнэлгээ

Хүснэгт 2. Орхоны хөндийн бүсэд багтах сумдын усны чанар

Аймаг	Сум	Нэн өндөр	Өндөр	Дунд
Архангай	Хашаат		+	
	Хотонт			+
	Өгийнуур			+
	Өлзийт			+
Булган	Могод			+
	Сайхан			+
	Гурванбулаг			+
Өвөрхангай	Хархорин	+		

Эх сурвалж: ХАНСХЕТ 2020, Ус хангамжийн үнэлгээ

Судалгааны бүсэд багтах сумдын усны чанарын хувьд Архангай аймгийн Хашаат сум өндөр, Хотонт, Өгийнуур, Өлзийт, Булган аймгийн Могод, Сайхан, Гурванбулаг дунд, Өвөрхангай аймгийн Хархорин сум нэн өндөр ангилалд багтаж байна.

Монгол орны хэмжээнд 10.8 км^3 газрын доорх усны ашиглалтын баримжаат нөөц байдаг. Архангай, Булган, Өвөрхангай аймагт газрын доорх усны боломжит нөөц 1.63 км^3 буюу улсын нийт газрын доорх усны нөөцийн 10.8 хувийг эзэлнэ. Ашиглаж болох баримжаат нөөц нь улсын нийт ашиглаж болох нөөцийн 14.8 хувийг эзэлнэ.

Хүснэгт.3. Ус ашиглалтын байдал

Аймаг	Унд, ахуй	МАН	Усалгаатай тариалан	Нийтийн аж ахуй	Үйлдвэр	ЭХ	Уул уурхай	Нийт
Архангай	0.23	11.7	1.31	0.19	0.01	0.009	1.00	14.45
Булган	0.15	7.57	4.5	0.04	0.00	0.001	1.65	13.91
Өвөрхангай	0.3	9.98	6.98	0.11	0.10	0.0	0.32	17.79
Нийт	0.68	29.25	12.79	0.34	0.11	0.01	2.97	46.15

Эх сурвалж: ХАНСХЕТ 2020, Ус хангамжийн үнэлгээ

Судалгаанд хамрагдаж буй 3 аймгийн ус ашиглалтыг авч үзвэл томоохон уул уурхай байхгүй, харин хөдөө аж ахуйн салбарын ус ашиглалт өндөр байна. Мал аж ахуйн хэрэглээ бусад аймгуудаас өндөр байсан бол усалгаатай газар тариалан Булган, Өвөрхангай аймагт өндөр байна.


Хүснэгт 4. Ус хангамжийн эх үүсвэрүүдийн усны чанарын үзүүлэлт

№	Сум	Дээжийн тоо	Физик үзүүлэлт	Химийн үзүүлэлт	Бохирдлын үзүүлэлт	Бичил амьсудлал	Хүнд метал	Тайлбар
1	Өгийнуур	1	+	+	+	**	**	Физик, хими, бохирдлын үзүүлэлтээр стандарт шаардлага хангаж байна.
2	Өлзийт	1	+	+	+	**	**	
3	Хашаат	1	+	+	+	**	**	
4	Хотонт	1	+	+	+	**	**	
5	Сайхан	3	+	+	+	**	**	
6	Могод	3	+	-	+	**	**	2 худгийн физик, хими, бохирдлын үзүүлэлт шаардлага хангаж байгаа бол 1 худгийн ус магний ионы агууламж стандартаас давсан.
7	Гурванбулаг	5	-	-	+	**	**	3 худгийн магни, нэг худгийн цахилгаан дамжуулах чанар, магни, ионы агууламж стандарт шаардлага хангахгүй байна.
8	Хархорин	5	+	-	+	**	**	1 худгийн усны эрдэсжилт, хатуулаг, магни, сульфат ионы агууламж стандарт шаардлага хангахгүй

Тайлбар: + стандарт шаардлага хангаж байгаа, ** судлах шаардлагатай

Цэвдэг, хүйтний үзэгдлийн тархалт. Судалгааны бүсэд багтах 3 аймгийн 8 сумаас Булган аймгийн Сайхан сум тохиолдлын тархалттай цэвдгийн бүсэд багтах бол бусад 7 сум улирлын хөлдөлтийн бүсэд багтана.

Зураг3. Цэвдэг хүйтний үзэгдлийн тархалт



Эх сурвалж: ХАНСХЕТ 2020, Цэвдэг хүйтний үзэгдлийн тархалт

Архангай аймгийн Хотонт, Булган аймгийн Сайхан сумын хувьд цэвдэг хүйтний үзэгдлийн хувьд хязгаарлагдмал тохиромжтой ангилал буюу алаг цоог тархалттай бүслүүрт багтаж байна. Мөн Булган аймгийн Могод, Сайхан, Архангай аймгийн Хотонт, Өлзийт, Өвөрхангай аймгийн Хархорин зэрэг сумд тохиромжтой ангилал буюу тохиолдлын тархалттай бүслүүрт багтаж байна. Бусад сумын хувьд нэн тохиромжтой буюу улирлын хөлдөлтийн бүсэд хамаарагдаж байна. Алаг цоог тархалттай бүслүүрийн талбай 975 км² буюу 5.2%, тохиолдлын тархалттай

бүслүүрийн талбай 2903 км² 15.3%, улирлын хөлдөлтийн бүслүүрийн талбай 15048 км² буюу 79.5%-ийг тус тус эзэлж байна.


Орчны бохирдол: /Агаар, ус, хөрс, цацрагийн, дуу чимээний бохирдол/ Судалгаанд хамрагдаж буй сумд нь агаарын, усны, хөрсний, цацрагийн болон дуу чимээний бохирдол байхгүй бөгөөд харин хогийн менежментийн зохицуулалт шаардлагатай байна.

Цөлжилт, газрын доройтол: Архангай аймаг 2015 оны байдлаар нийт нутгийн 73.3 хувь нь цөлжилтөд өртсөнөөс 9.6 хувь нь нэн хүчтэй, 15.8 хувь нь хүчтэй, 31.1 хувь нь дунд, 16.8 хувь нь сул ангилалд багтаж байна. 2019 оны байдлаар 15236 малчин өрхийн 6.1 сая мал тоологдсоноос адуу 425.9 мян, үхэр 710 мян, тэмээ 1.4 мян, хонь 3.3 сая, ямаа 1.7 сая байна. Судалгаанд багтсан Өгийнуур, Өлзийт, Хашаат, Хотонт сумын нутагт эвдэрсэн газар бүртгэгдээгүй.

Булган аймгийн газар нутаг 2015 оны байдлаар нийт нутгийн 65.9 хувь нь цөлжилтөд өртсөн бөгөөд 15.7 хувь нь нэн хүчтэй, 15.2 хувь нь хүчтэй, 24.7 хувь нь дунд, 10.3 хувь нь сул ангилалд багтаж байна. 2019 оны байдлаар 8526 малчин өрхийн 3.6 сая мал тоологдсоноос 272 мян адуу, 282.4 мян үхэр, 1.4 мян тэмээ, 1.9 сая хонь, 1.1 сая ямаа тоологдсон. Бэлчээр ашиглалтаар сумдын малын тоо толгойн зохистой хэмжээнээс хэтэрсэн байна. Сайхан сумын нутагт 6 байршилд 32.8 га талбай эвдэрсэн байна.

Өвөрхангай аймгийн газар нутаг 2015 оны байдлаар 96 хувь нь цөлжилтөд өртсөнөөс 6.3 хувь нь нэн хүчтэй, 33.4 хувь нь хүчтэй, 46.9 хувь нь дунд, 9.4 хувь нь сул ангилалд орно. 2019 оны байдлаар 16398 малчин өрхийн 5.6 сая мал тоологдсон. Эндээс адуу 348.9 мян, үхэр 292.4 мян, тэмээ 32.7 мян, хонь 2.6 сая, ямаа 2.3 сая байна. Аймгийн хэмжээнд бэлчээр ашиглалт 1-2 дахин хэтэрсэн байна. Хархорин суманд эвдэрсэн газар бүртгэгдээгүй.

Зураг 4. Цөлжилт, газрын доройтол




Эх сурвалж: ХАНСХЕТ 2020, Цөлжилт, газрын доройтол

Дээрх зургаас харахад нийт нутаг дэвсгэрийн хувьд цөлжилт, газрын доройтлын хувьд илрээгүй 5.7 хувь, сул 5.6 хувь, дунд 63.7 хувь, хүчтэй 10.6 хувь, нэн хүчтэй 10.6 хувь эзэлж байна. Архангай аймгийн Хашаат, Өгийнуур, Өлзийт зэрэг сумд нэн хүчтэй ангилалд эзлэх хувь өндөр үзүүлэлттэй байгаа нь цөлжилт, газрын доройтол их байгаа нь харагдаж байна. Цөлжилт, газрын доройтлын төлөв сүүлийн 15 жилийн хугацаанд муудах хандлага ажиглагдаж, улмаар доройтлын дунд, хүчтэй, нэн хүчтэй зэрэглэлийн хамрах талбай нэмэгдсэн байна. Швейцарын Хамтын ажиллагааны агентлагаас хэрэгжүүлж буй Монголын бэлчээр Ногоон алт хөтөлбөр, Бэлчээрийн тогтвортой менежмент, Цөлжилттэй тэмцэх нь зэрэг төслийн хүрээнд Булган аймгийн Гурван булаг, Архангай аймгийн Хашаат сумдын нутагт цөлжилтийн

төлөв байдал, учир шалтгаан, нөлөөлөх хүчин зүйлсийг илрүүлэх цаашид мониторинг судалгаа хийх зорилгоор судалгааны цэгүүдэд давтан хэмжилт, ажиглалт явуулж байна. Мөн Булган, Өвөрхангай аймгийн зааг нутаг “Элсэн тасархай”-д “Цөлжилттэй тэмцэх туршилт, судалгааны төв” байгуулан туршилт судалгаа, мониторингийн ажлууд явуулж ирсэн.

Уур амьсгал: Уур амьсгалын өөрчлөлт нь хүлэмжийн хийн ялгарал болон хүний шууд нөлөөтэй бэлчээр, ой, усны нөөцийг бууруулах зэрэг газрын бүрхэвчийн доройтол хэлбэрээр илэрч байна. Монгол оронд дээрх хоёр нөлөө зэрэг үйлчилж байгаа бөгөөд дэлхийн уур амьсгалын өөрчлөлтөд нэн эмзэг 10 улсын тоонд багтдаг. Агаарын температур 1940-2018 оны хооронд 2.25°C -ээр нэмэгдэж, хур тунадас өвлийн улиралд 24 хувиар нэмэгдсэн бол зуны хур тунадас 7 хувиар буурсан үр дүн гарсан. Хэт хуурайшилт эрчимтэй явагдаж байгаагаас гол, нуур хатаж, ширгэх, бэлчээрийн ургамлын бүрхэвч доройтох зэрэг сөрөг үр дагавар гарч байна. Ирээдүйд уур амьсгалын өөрчлөлт нэмэгдэж байгааг мэргэжлийн судлаачдын судалгаа харуулж байна.


Хүн амын амьдрах орчны тохиромжтой байдлын ангиллын хувьд нэн тохиромжгүй буюу хэт хуурай-дулаан болон хэт чийглэг-сэрүүн ангиллын талбайн хэмжээ 1970 км^2 бөгөөд нийт нутаг дэвсгэрийн 10.4 хувь, хязгаарлагдмал тохиромжтой буюу чийг дутмаг дулаан 202 км^2 бөгөөд 1.1 хувь, тохиромжтой буюу чийглэг сэрүүн ангилал 8082 км^2 бөгөөд 42.7 хувь, нэн тохиромжтой буюу чийглэгдүү дулаан ангилал 8673 км^2 бөгөөд 45.8 хувийг тус тус эзэлж байна.




Зураг 5. Уур амьсгалын үнэлгээ

Эх сурвалж: ХАНСХЕТ 2020, Уур амьсгалын үнэлгээ

Зураг 6. Хур тунадас



Зураг 7. Агаарын дундаж температур



Тайлбар: Судалгааны хүрээнд боловсруулав


Дээрх 2 зургаас харахад хур тунадасны хувьд Орхоны хөндийн бүсэд багтах 3 аймгийн 8 сумын нутаг дэвсгэр Орхон-Туулын хээрийн болон Архангай, Булган, Сэлэнгийн ойт хээрийн бүсэд багтана. Агаарын жилийн дундаж температур нь -3°C – -1°C -ийн хооронд бол хур тунадасны жилийн нийлбэр 250–400 мм-н хооронд хэлбэлзэнэ.

Байгалийн бүс бүслүүр: Архангай аймгийн Өлзийт, Булган аймгийн Гурванбулаг, Могод сумдын хувьд өргөрөгийн бүсийн хувьд хээрийн бүсэд багтаж нугат хээр (10-20%), Архангай аймгийн Өгийнуур, Хотонт, Өвөрхангай аймгийн Хархорин сумын хувьд өмнөд хэсэг хуурай хээр (10-20%) ба нугат хээр (10-20%), Булган аймгийн Сайхан сумын хувьд Ойт хээрийн бүсэд ой (10-20%), ойт хээр (10-20%), хээр (10%-иас бага), Архангай аймгийн Хашаат сумын хувьд хээр (10%-иас бага), мараа-марз (10%-иас бага) бүхий хээрийн бүсэд багтаж байна.

1.2. Газрын гадаргын үнэлгээ

Судалгааны бүс болох Орхоны хөндийн нутаг дэвсгэр нь далайн төвшнөөс дээш 1000 метрээс дээш өндрийн бүслүүрт оршдог. Нийт нутаг дэвсгэрийн 9 орчим хувь нь 1000-1250 метрийн өндөрт хамаарагдаж байна. Уг газарт Өгийнуур сумын төв, Өгийнуурын хэсэг тэгшивтэр тал газар байгаа бол 1250-1500 метрийн өндөртэй нийт талбайн 45 хувь орчимыг эзлэж байна. Энэ өндөрт харьцангуй гүвээрхэг уулын бэл, голын гольдрил дагасан хөндий тэгшивтэр тал хамаарагдаж байгаа бол 1500-2000 метрийн бүслүүрт нутаг дэвсгэрийн 55 хувь оршиж байна. Тус талбайд уул толгод, уулын бүс газрын гадаргын налуу ихтэй талбай эзлэж байгаа бол 2000 метрээс дээш өндөрт өндөр уулын орой хэсэг багтаж байна.


Зураг 8. Газрын гадаргын үнэлгээ



Тайлбар: Судалгааны хүрээнд боловсруулав


Орхон-Тамирын бэлчирт нийслэлийн баримжаатай шинэ хот байгуулах Архангай аймгийн Өгийнуур суманд байрлах шинэ хотын газрын гадаргын үнэлгээг газрын гадаргын өндөржилт, налуу гэсэн 2 үзүүлэлтээр үнэлэв.

Зураг 9. Газрын гадаргын өндөржилтийн үнэлгээ




Өндөржилтийн үнэлгээг 10000 га нутаг дэвсгэрт гүйцэтгэсэн бөгөөд нийт 13.3 хувь нь хязгаарлагдмал тохиромжтой, 20.4 хувь нь тохиромжтой, 66.3 хувь нь нэн тохиромжтой гэж үнэлэгдсэн ба нутаг дэвсгэрийн өндөржилтийн жигнэсэн дундаж үнэлгээ нь тохиромжтой гэж үнэлэгдэж байна.

Зураг 10. Газрын гадаргын налуужилтын үнэлгээ



Газрын гадаргын налуужилтын үнэлгээний хувьд нийт нутаг дэвсгэрийн 76.7 хувь нь нэн тохиромжтой, 15.4 хувь нь тохиромжтой, 7.9 хувь хязгаарлагдмал тохиромжтой гэж үнэлэгдсэн ба нутаг дэвсгэрийн хувьд налуужилтын жигнэсэн дундаж үнэлгээ нь тохиромжтой гэж үнэлэгдэж байна.

Зураг 11. Газрын гадаргын нэгдсэн үнэлгээ



Газрын гадаргын нэгдсэн үнэлгээний хувьд нийт нутаг дэвсгэрийн 78.3 хувь нь нэн тохиромжтой, 16.4 хувь нь тохиромжтой, 5.3 хувь нь хязгаарлагдмал тохиромжтой гэж үнэлэгдсэн ба нутаг дэвсгэрийн хувьд газрын гадаргын нэгдсэн жигнэсэн дундаж үнэлгээ нь тохиромжтой гэж үнэлэгдэж байна.

Дээрх зургаас авч үзвэл VII баллын нөлөөллийн бүсэд 41.5 хувь, VIII баллын нөлөөллийн бүсэд 39.3 хувь, IX баллын нөлөөллийн бүсэд 12.2 хувь, X баллын нөлөөллийн бүсэд 6.8 хувь нь хамрагдаж байна. Булган аймгийн Могод сум газар хөдлөлтийн X балл буюу хамгийн өндөр, Архангай аймгийн Хотонт, Хашаат, Өвөрхангай аймгийн Хархорин сумд VII баллын бүсэд, Архангай аймгийн Өгийнуур, Булган аймгийн Гурванбулаг сумын нутаг дэвсгэрийн 50 орчим хувь нь VII балл, бусад хэсэг нь VIII баллын нөлөөнд, Булган аймгийн Сайхан, Архангай аймгийн Өлзийт сумд VIII баллын нөлөөллийн бүсэд хамаарагдаж байна. Ерөнхийдөө энэ бүс нутаг нь баруун хойноос зүүн урагш газар хөдлөлийн баллын нөлөө буурч байна.

Хүснэгт 5. Томоохон хагаралууд

№	Аймаг	Сум	Хагаралын нэр	Нийт урт /км/	Бүсэд хамрагдах урт /км/
1	Өвөрхангай	Хужирт	Хужиртын хагарал	21	14.85
2	Өвөрхангай	Бүрд	Мөстийн цагаан хагарал	25	14.03
3	Булган	Могод	Могодын хагарал	45	51.38
4	Архангай	Өлзийт	Өлзийтийн хагарал	70	51.29

Эх сурвалж: ХАНСХЕТ-2020, ШУА-ийн Одон орон геофизикийн судалгааны хүрээлэн

Энэ район нь идэвхтэй хагарлууд ихтэй, газар хөдлөлийн балл VII-X буюу газар хөдлөлийн балл өндөртэй бүс нутаг юм. Энэ мужлалт нь тухайн газар нутгийг бүрэн тодорхойлж чадахгүй бөгөөд хот байгуулалтын үйл ажиллагаа явуулахаас өмнө тухайн газар нутгийн хэмжээнд газар чичирхийллийн бичил мужлалтын зургийг боловсруулах шаардлагатай.

Хүснэгт 6. 500 болон 2500 жилийн давтагдах хугацааны ХОХ болон MSK64 шаталбарын баллын утгууд

№	Аймаг	Сум	500		2500		Барилгын норм дүрэмд ашиглагдаж байгаа
			см/с ²	балл	см/с ²	балл	балл
1	Өвөрхангай	Хархорин	110 - 130	VII	262 - 282	VIII	VIII-IX
2	Архангай	Өгийнуур	127 - 147	VII	272 - 292	VIII	VIII
3		Өлзийт	194 - 214	VIII	389 - 409	IX	IX
4		Тариат	85 - 105	VII	239 - 259	VIII	IX
5		Хашаат	119 - 139	VII	263 - 283	VIII	VIII-IX
6		Хотонт	110 - 130	VII	258 - 278	VIII	VIII
7	Булган	Гурванбулаг	140 - 160	VIII	271 - 291	IX	IX
8		Могод	703 - 723	X	993 - 1013	XI	IX
64		Сайхан	144 - 164	VIII	322 - 342	IX	VIII-IX

Эх сурвалж: ХАНСХЕТ 2020, ШУА-ийн Одон орон геофизикийн судалгааны хүрээлэн

1.4. Инженер геологи

Архангай аймаг Өгийнуур сум

Геоморфологийн хэв шинж. Судалгааны район геоморфологийн мужлалтаар Орхон Сэлэнгийн бэсрэг уулсын их мужийн Туулын дэд мужид хамаарагдана. Сумын төв байрлаж буй хэсэгт хотгор гүдгэрийн 1 хэв шинж ажиглагдана. Үүнд:

- Голын хөндийн хуримтлалын хэв шинж: Орхон голын татам, нуга, хөндий орчим энэ хэсэгт хамаарагдана. Геологийн тогтоц. Судалгааны талбайн геологийн тогтцыг дээд дөрөвдөгчийн настай, аллювийн гаралтай сэвсгэр хурдас тодорхойлно. Голлох хурдас нь хэмхдэс материал янз бүрийн хэмжээгээр агуулсан элсэн хөрс байна.

Гидрогеологийн нөхцөл. Судалгааны талбайд өрөмдсөн цооногуудад хөрсний ус 1.23-3 м гүнд илэрсэн. Хөрсний ус нь Орхон голын устай гидравлик холбоотой ба хур бороо болон үерлэлтийн үед түвшний нэмэгдэл 0.4-0.6 м байна.

Районы инженер-геологийн нөхцөл. Судалгааны талбайн геологийн тогтцыг дээд дөрөвдөгчийн настай, аллювийн гаралтай сэвсгэр хурдас тодорхойлно. Голлох хурдас нь хэмхдэс материал янз бүрийн хэмжээгээр агуулсан элсэн хөрс байна. Дөрөвдөгчийн настай сэвсгэр хөрснүүдийг тэдгээрийн нас, гарал үүсэл, ширхгийн бүрэлдэхүүн, физик-механик шинж чанараас нь хамааруулан инженер-геологийн 2 элементэд ангилав. Дээд дөрөвдөгч-орчин үеийн настай аллювийн гаралтай хурдасны геологи-гарал үүслийн комплекс /аQ2/ ИГЭ-1. Элсэн чигжээстэй хайр, хайрган хөрс Бор саарал, бор шаргал, шаргал өнгөтэй, бага чийгтэйгээс усаар ханасан, элсэн чигжээстэй хайр, хайрга хөрс сумын төвийн нийт талбайн хэмжээнд үндсэн хөрс байдлаар хуримтлагдсан. ИГЭ-2. Тоосорхог элсэн хөрс Бор саарал өнгөтэй, бага чийгтэйгээс усаар ханасан, тоосорхог элс хөрс сумын төвийн зүүн урд хэсгээр хучаас байдлаар багахан талбайд тархсан.

Архангай аймаг Өлзийт сум

Геоморфологийн хэв шинж. Судалгааны район геоморфологийн мужлалтаар Хангайн их мужийн Хануйн дэд мужид хамаарагдана. Сумын төв байрлаж буй хэсэгт хотгор гүдгэрийн 1 хэв шинж ажиглагдана. Үүнд:

- Голын хөндийн хуримтлалын хэв шинж: Орхон голын татам, нуга, хөндий орчим энэ хэсэгт хамаарагдана. Геологийн тогтоц. Судалгааны талбайн геологийн тогтцыг дээд дөрөвдөгчийн настай, пролювийн гаралтай сэвсгэр хурдас тодорхойлно. Голлох хурдас нь хэмхдэс материал янз бүрийн хэмжээгээр агуулсан элсэн хөрс байна. Гидрогеологийн нөхцөл. Судалгааны талбайд өрөмдсөн цооногуудад хөрсний ус илрээгүй.

Районы инженер-геологийн нөхцөл. Судалгааны талбайн геологийн тогтцыг дээд дөрөвдөгчийн настай, пролювийн гаралтай сэвсгэр хурдас тодорхойлно. Голлох хурдас нь хэмхдэс материал янз бүрийн хэмжээгээр агуулсан элсэн хөрс байна. Дөрөвдөгчийн настай сэвсгэр хөрснүүдийг тэдгээрийн нас, гарал үүсэл, ширхгийн бүрэлдэхүүн, физик-механик шинж чанараас нь хамааруулан инженер-геологийн 3 элементэд ангилав. Дээд дөрөвдөгч-орчин үеийн настай пролювийн гаралтай хурдасны геологи-гарал үүслийн комплекс /рQ2// ИГЭ-1. Сайргархаг элсэн хөрс Бор шаргал өнгөтэй, сайргархаг элсэн хөрс

сумын төвийн баруун хэсгээр талбайн тархалттай. ИГЭ-2. Элсэн чигжээстэй сайр, сайрган хөрс Бор шаргал өнгөтэй, бага чийгтэй, элсэн чигжээстэй сайр, сайран хөрс сумын төвийн зүүн болон урд хэсгээр үндсэн хөрс байдлаар хуримтлагдсан. ИГЭ-3. Шавранцар хөрс Бор шаргал өнгөтэй, зөөлөн уян налархай консистенцтэй, шавранцар хөрс сумын төвийн урд хэсэгт багахан талбайд хуримтлагдсан.

Архангай аймаг Хашаат сум

Геоморфологийн хэв шинж. Судалгааны район геоморфологийн мужлалтаар Орхон-Сэлэнгийн бэсрэг уулсын их мужийн Туулын дэд мужид хамаарагдана. Сумын төв байрлаж буй хэсэгт хотгор гүдгэрийн 1 хэв шинж ажиглагдана. Үүнд:

- Бэл хормойн элэгдэл-хуримтлалын хэв шинжит гадаргуу: Сумын төвийн нутаг дэвсгэр нь бүхлээрээ Гүнгийн хөтөл уулын бэл хормойн элэгдэл-хуримтлалын хэв шинжит гадаргууд хамаарагдана. Геологийн тогтоц. Судалгааны талбайн геологийн тогтцыг дээд дөрөвдөгчийн настай, делюви-пролювийн гаралтай сэвсгэр хурдас тодорхойлно. Голлох хөрс нь тоосорхог элс, элсэн чигжээстэй хайр, хайрга, шавранцар, шавар байна. Гидрогеологийн нөхцөл. Судалгааны талбайд өрөмдсөн 4 ш цооногт хөрсний ус 5.4-6.6 м хооронд илэрсэн.

Районы инженер-геологийн нөхцөл. Судалгааны талбайн геологийн тогтцыг дээд дөрөвдөгчийн настай, делюви-пролювийн гаралтай сэвсгэр хурдас тодорхойлно. Голлох хөрс нь тоосорхог элс, элсэн чигжээстэй хайр, хайрга, шавранцар, шавар байна. Дөрөвдөгчийн настай сэвсгэр хөрснүүдийг тэдгээрийн нас, гарал үүсэл, ширхгийн бүрэлдэхүүн, физик-механик шинж чанараас нь хамааруулан инженер-геологийн 4 элементэд ангилав. Дээд дөрөвдөгч-орчин үеийн настай, делюви-пролювийн гаралтай хурдасны геологи-гарал үүслийн комплекс /dpQ2/ ИГЭ-1. Элсэн чигжээстэй хайр, хайрган хөрс Бор шаргал өнгөтэй, бага чийгтэй, элсэн чигжээстэй хайр, хайрган хөрс сумын төвийн урд хэсгээр хучаас байдлаар тархсан. ИГЭ-2. Тоосорхог элсэн хөрс Бор шаргал өнгөтэй, бага чийгтэй, тоосорхог элсэн хөрс сумын төвийн төв болон зүүн хойд хэсгээр хучаас байдлаар, зүүн урд хэсгээр зузаалаг байдлаар хуримтлагдсан. ИГЭ-3. Шавар хөрс Улаан хүрэн өнгөтэй, хагас хатуугаас агиуун консистенцтэй, шавар хөрс сумын төвийн нийт хэсгээр зузаалаг байдлаар хуримтлагдсан. ИГЭ-4. Шавранцар хөрс Бор саарал, улаан хүрэн өнгөтэй, хатуугаас хагас хатуу консистенцтэй, шавранцар хөрс сумын төвийн зүүн урд хэсгээр хучаас байдлаар хуримтлагдсан.

Архангай аймаг Хотонт сум

Геоморфологийн хэв шинж. Судалгааны район геоморфологийн мужлалтаар Орхон-Сэлэнгийн бэсрэг уулсын их мужийн Туулын дэд мужид хамаарагдана. Сумын төв байрлаж буй хэсэгт хотгор гүдгэрийн 1 хэв шинж ажиглагдана. Үүнд:

- Бэл хормойн элэгдэл-хуримтлалын хэв шинжит гадаргуу: Сумын төвийн нутаг дэвсгэр нь бүхлээрээ Ухаа толгой уулын бэл хормойн элэгдэл-хуримтлалын хэв шинжит гадаргууд хамаарагдана. Геологийн тогтоц. Судалгааны талбайн геологийн тогтцыг Түрүү-Дунд Пермийн настай, гүний чулуулаг тодорхойлно. Гүний чулуулаг боржингоос тогтох ба түүнийг дөрөвдөгчийн настай сэвсгэр хурдас хучиж тогтсон байна. Гидрогеологийн нөхцөл. Судалгааны талбайд өрөмдсөн цооногуудад хөрсний ус илрээгүй.

Районы инженер-геологийн нөхцөл. Судалгааны талбайн геологийн тогтцыг Неопротерозойн настай, хувирмал чулуулаг тодорхойлно. Хувирмал чулуулаг нь занар, элсэн чулуунаас бүрдэнэ. Үндсэн чулуулгийг дээд дөрөвдөгчийн настай, делюви-пролюви болон элювийн гаралтай сэвсгэр хурдас хучиж тогтсон байна. Дөрөвдөгчийн настай сэвсгэр хөрсүүд, хувирмал чулуулгуудыг тэдгээрийн нас, гарал үүсэл, ширхгийн бүрэлдэхүүн, физик-механик шинж чанараас нь хамааруулан инженер геологийн 8 элементэд ангилав. Дээд дөрөвдөгч-орчин үеийн настай, делюви-пролювийн гаралтай хурдасны геологи-гарал үүслийн комплекс /dpQ2/ ИГЭ-1. Элсэн чигжээстэй сайр, сайрган хөрс Шаргал өнгөтэй, бага чийгтэй, элсэн чигжээстэй сайр, сайрган хөрс сумын төвийн төв болон зүүн урд хэсгээр хучаас болон зузаалаг байдлаар тархсан. ИГЭ-2. Тоосорхог элсэн хөрс Шаргал өнгөтэй, бага чийгтэйгээс чийгтэй, тоосорхог элсэн хөрс сумын төвийн зүүн хэсгээр хучаас байдлаар тархсан. ИГЭ-3. Элсэнцэр чигжээстэй сайр, сайрган хөрс Цайвар шаргал, шаргал өнгөтэй, хатуу консистенцтэй, элсэнцэр чигжээстэй сайр, сайрган хөрс сумын төвийн төв хэсгээр хучаас байдлаар урд хэсгээр зузаалаг байдлаар хуримтлагдсан. ИГЭ-4. Сайр, сайрга агуулсан элсэнцэр хөрс Шаргал өнгөтэй, хатуу консистенцтэй, сайр, сайрга агуулсан элсэнцэр хөрс сумын төвийн төв хэсгээр зузаалаг байдлаар, хойд хэсгээр хучаас байдлаар хуримтлагдсан. ИГЭ-5. Сайр, сайрга агуулсан шавранцар хөрс Улаавтар шаргал өнгөтэй, хатуугаас агилуун консистенцтэй, сайр, сайрга агуулсан шавранцар хөрс сумын төвийн төв болон баруун урд хэсгээр зузаалаг байдлаар байдлаар хуримтлагдсан. Дээд дөрөвдөгч-орчин үеийн настай, элювийн гаралтай хурдасны геологи-гарал үүслийн комплекс /eQ/ ИГЭ-6. Хайр хөрс Хайр хөрс /элсэн чулууны өгөршлийн бүс/ сумын төвийн баруун урд хэсгээр тархалттай.

Өвөрхангай аймаг Гурванбулаг сум

Геоморфологийн хэв шинж. Судалгааны район геоморфологийн мужлалтаар Орхон-Сэлэнгийн бэсрэг уулсын их мужийн Туулын дэд мужид хамаарагдана. Сумын төв байрлаж буй хэсэгт хотгор гүдгэрийн 1 хэв шинж ажиглагдана. Үүнд:

- Бэл хормойн элэгдэл-хуримтлалын хэв шинж: Сумын төв нь Ашилт уулын баруун бэл хормойн элэгдэл-хуримтлалын хэв шинжит гадаргууд оршино.

Геологийн тогтоц. Судалгааны талбайн геологийн тогтцыг дээд дөрөвдөгчийн настай, делюви-пролювийн гаралтай, сэвсгэр хурдас тодорхойлно. Голлох хурдас нь хэмхдэс материал бага хэмжээгээр агуулсан элсэн болон шаварлаг хөрс байна. Гидрогеологийн нөхцөл. Судалгааны талбайд өрөмдсөн цооногуудад хөрсний ус илрээгүй.

Районы инженер-геологийн нөхцөл. Судалгааны талбайн геологийн тогтцыг дээд дөрөвдөгчийн настай, делюви-пролювийн гаралтай, сэвсгэр хурдас тодорхойлно. Голлох хурдас нь хэмхдэс материал бага хэмжээгээр агуулсан элсэн болон шаварлаг хөрс байна. Дөрөвдөгчийн настай сэвсгэр хөрснүүдийг инженер-геологийн 3 элемент болгон авч үзлээ. Дээд дөрөвдөгч-орчин үеийн настай, делюви-пролювийн гаралтай хурдасны геологи-гарал үүслийн комплекс /dpQ2/

ИГЭ-1. Хайргархаг элсэн хөрс Бор саарал өнгөтэй, бага чийгтэй хайргархаг элсэн хөрс сумын төвийн зүүн хойд хэсгээр хучаас байдлаар хуримтлагдсан.

ИГЭ-2. Хайргархаг элсэнцэр хөрс Цайвар бор өнгөтэй хатуу консистенцтэй хайргархаг элсэнцэр хөрс сумын төвийн баруун урд хэсгээр 2-р үе байдлаар хуримтлагдсан.

ИГЭ-3. Жижиг ширхэгтэй элсэн хөрс Бор саарал өнгөтэй бага чийгтэй хайрга агуулсан жижиг ширхэгтэй элсэн хөрс сумын төвийн нийт хэсгээр зузаалаг байдлаар хуримтлагдсан.

Өвөрхангай аймаг Могод сум

Геоморфологийн хэв шинж. Судалгааны район геоморфологийн мужлалтаар Орхон-Сэлэнгийн бэсрэг уулсын их мужийн Туулын дэд мужид хамаарагдана. Сумын төв байрлаж буй хэсэгт хотгор гүдгэрийн 1 хэв шинж ажиглагдана. Үүнд: • Бэл хормойн элэгдэл-хуримтлалын хэв шинж: Сумын төв нь Номгон уулын зүүн бэл хормойн элэгдэл-хуримтлалын хэв шинжит гадаргууд оршино.

Геологийн тогтоц. Судалгааны талбайн геологийн тогтцыг доод Пермийн настай, Вулканоген чулуулаг тодорхойлно. Вулканоген чулуулаг нь андезитээс бүрдэнэ. Үндсэн чулуулгийг дээд дөрөвдөгчийн настай, делюви-пролювийн гаралтай сэвсгэр хурдас хучиж тогтсон байна. Гидрогеологийн нөхцөл. Судалгааны талбайд өрөмдсөн цооногуудад хөрсний ус илрээгүй. 2. РАЙОНЫ ИНЖЕНЕР-ГЕОЛОГИЙН НӨХЦӨЛ Судалгааны талбайн геологийн тогтцыг доод Пермийн настай, Вулканоген чулуулаг тодорхойлно. Вулканоген чулуулаг нь андезитээс бүрдэнэ. Үндсэн чулуулгийг дээд дөрөвдөгчийн настай, делюви-пролювийн гаралтай сэвсгэр хурдас хучиж тогтсон байна. Дөрөвдөгчийн настай сэвсгэр хөрснүүд, Вулканоген гаралтай хадан хөрснүүдийг инженер геологийн 5 элемент болгон авч үзлээ. Дээд дөрөвдөгч-орчин үеийн настай, делюви-пролювийн гаралтай хурдасны геологи-гарал үүслийн комплекс /dpQ2/

ИГЭ-1. Хайргархаг шавранцар хөрс Бор шаргал өнгөтэй, хатуу консистенцтэй хайргархаг шавранцар хөрс сумын төвийн нийт хэсгээр хучаас байдлаар хуримтлагдсан.

ИГЭ-2. Элсэнцэр чигжээстэй хайр, хайрган хөрс Бор шаргал өнгөтэй, хатуу консистенцтэй элсэнцэр чигжээстэй хайр, хайрган хөрс сумын төвийн зарим хэсгээр зузаалаг байдлаар хуримтлагдсан.

ИГЭ-3. Хайргатай шавар хөрс Бор шаргал өнгөтэй, хатуу консистенцтэй хайргатай шавар хөрс сумын төвийн төв хэсгээр хучаас байдлаар хуримтлагдсан.

ИГЭ-4. Шавар хөрс Бор шаргал өнгөтэй, хатуу консистенцтэй шавар хөрс сумын төвийн урд хэсгээр хучаас байдлаар хуримтлагдсан. Доод Пермийн настай, вулканоген чулуулгийн геологи-гарал үүслийн комплекс /P1/ ИГЭ-5. Андезит Андезит чулуу сумын төвийн Номгон уул болон Дэжээ толгойн бэл хормойгоор илэрцтэй.

Өвөрхангай аймаг Сайхан сум

Геоморфологийн хэв шинж. Судалгааны район геоморфологийн мужлалтаар Орхон-Сэлэнгийн бэсрэг уулсын их мужийн Туулын дэд мужид хамаарагдана. Сумын төв байрлаж буй хэсэгт хотгор гүдгэрийн 1 хэв шинж ажиглагдана. Үүнд: • Бэл хормойн элэгдэл-хуримтлалын хэв шинж: Сумын төв нь Цохиот уулын урд бэл хормойн элэгдэл-хуримтлалын хэв шинжит гадаргууд оршино. Геологийн тогтоц. Судалгааны талбайн геологийн тогтцыг доод

Палеозойн настай, гүний чулуулаг тодорхойлно. Гүний чулуулаг нь боржингоос бүрдэнэ. Үндсэн чулуулгийг дээд дөрөвдөгчийн настай, делювийн гаралтай сэвсгэр хурдас хучиж тогтсон байна.

Гидрогеологийн нөхцөл. Судалгааны талбайд өрөмддөг цооногуудад хөрсний ус илрээгүй.

РАЙОНЫ ИНЖЕНЕР-ГЕОЛОГИЙН НӨХЦӨЛ. Судалгааны талбайн геологийн тогтцыг доод Палеозойн настай, гүний чулуулаг тодорхойлно. Гүний чулуулаг нь боржингоос бүрдэнэ. Үндсэн чулуулгийг дээд дөрөвдөгчийн настай, делювийн гаралтай сэвсгэр хурдас хучиж тогтсон байна. Дөрөвдөгчийн настай сэвсгэр хөрснүүд, гүний гаралтай хадан хөрснүүдийг инженергеологийн 3 элемент болгон авч үзлээ. Дээд дөрөвдөгч-орчин үеийн настай, делюви-пролювийн гаралтай хурдасны геологи-гарал үүслийн комплекс /dpQ1-2/

ИГЭ-1. Шавранцар хөрс Цайвар шаргал, улаан хүрэн өнгөтэй, хатуу консистенцтэй шавранцар хөрс сумын төвийн ихэнх хэсгээр хучаас байдлаар хуримтлагдсан.

ИГЭ-2. Хайргархаг элсэн хөрс Цайвар шаргал өнгөтэй, бага чийгтэй хайргархаг элсэн хөрс сумын төвийн ихэнх хэсгээр хучаас байдлаар хуримтлагдсан. Доод Палеозойн настай, гүний чулуулгийн геологи-гарал үүслийн комплекс /үР1/

ИГЭ-3. Боржин Цайвар саарал өнгөтэй боржин чулуу сумын төвийн баруун хойд болон зүүн хойд хэсгээр үндсэн зузаалаг байдлаар тогтсон.

Өвөрхангай аймгийн Хархорин сум

Геоморфологийн хэв шинж. Судалгааны район геоморфологийн мужлалтаар голын хөндийн муж, уулс хоорондын хөндийн мужид хамаарагдана. Сумын төв байрлаж буй хэсэгт хотгор гүдгэрийн 2 хэв шинж ажиглагдана. Үүнд:


- аллюви-пролювийн гаралтай хуримтлал - зөөгдлийн хэв шинжит гадаргуу: сумын төвийн хойд хэсэг энэ хэв шинжид хамаарна.
- Делювийн гаралтай элэгдлийн хэв шинжит гадаргуу: сумын төвийн урд хэсгийн гадаргуу энэ хэв шинжид хамаарна.

Геологийн тогтоц. Судалгааны талбайн геологийн тогтцыг дээд дөрөвдөгч-орчин үеийн настай аллюви-пролюви, делювийн гаралтай сэвсгэр хурдасаар хучиж тогтсон байна. Зонхилох хурдас нь элсэнцэр, тоосорхог элс, шавранцар, хайргархаг элсэн хөрснөөс тогтоно. Гидрогеологийн нөхцөл. Судалгааны талбайд өрөмдсөн цооногуудад хөрсний ус 7.5-10.0м ус илэрч тогтсон байна.

Районы инженер-геологийн нөхцөл. Судалгааны талбайн геологийн тогтцыг дээд дөрөвдөгч-орчин үеийн настай аллюви-пролюви, делювийн гаралтай сэвсгэр хурдсаар хучиж тогтсон байна. Зонхилох хурдас нь элсэнцэр, тоосорхог элс, шавранцар, хайргархаг элсэн хөрснөөс тогтоно. Дээд дөрөвдөгч-орчин үеийн настай аллюви-пролюви, делювийн гаралтай сэвсгэр хурдсуудыг тэдгээрийн нас, гарал үүсэл, ширхэгийн бүрэлдэхүүн, физик-механик шинж чанараас нь хамааруулан инженер-геологийн 4 элементэд ангилав. Дээд дөрөвдөгч-орчин үеийн настай аллюви-пролювийн гаралтай хурдасны геологи-гарал үүслийн комплекс /арQ2/ ИГЭ-1. Элсэнцэр хөрс Бор хүрэн өнгөтэй, хатуу консистенцтэй, элсэнцэр хөрс нь сумын төвийн урд хэсгээр хучаас байдлаар тархсан байна. ИГЭ-2. Тоосорхог элсэн хөрс Бор шаргал өнгөтэй, бага чийгтэй тоосорхог элсэн хөрс нь

сумын төвийн дунд болон урд хэсгээр хучаас байдлаар тархсан байна. Дээд дөрөвдөгч-орчин үеийн настай делювийн гаралтай хурдасны геологи-гарал үүслийн комплекс /dQ2/ ИГЭ-3. Сайрга агуулсан шавранцар хөрс Бор шаргал өнгөтэй, бага чийгтэй сайрга агуулсан шавранцар хөрс нь сумын төвийн дунд хэсгээр суурин байдлаар тархсан байна. Дээд дөрөвдөгч-орчин үеийн настай аллюви-пролювийн гаралтай хурдасны геологи-гарал үүслийн комплекс /apQ2/ ИГЭ-4. Хайргархаг элсэн хөрс Шаргал өнгөтэй, хайргархаг элсэн хөрс нь сумын төвийн хойд хэсгээр хучаас байдлаар тархсан байна.

Зураг 13. Монгол орны барилгажилтад зориулсан байгалийн мужлалт




Эх сурвалж: Монгол орны хот байгуулалтын байгалийн нөхцөл, Ц.Хоролжав, 2011

Судалгааны бүсийн хувьд барилгын уур амьсгалын мужлалын хувьд I болон II-р бүсэд хамаарагдаж байна. Нийт нутаг дэвсгэрийн хэмжээнд I-р бүс 87.9 хувь, II-р бүс 12.1 хувийг тус тус эзэлж байна. Нэгдүгээр муж: Нийт гадаргад ухаа, гүвээ, тэгш талын хэв шинж зонхилно. Инженерийн барилга байгууламжид нөлөөлөх байгалийн хүчин зүйлүүд болох газар хөдлөлийн балл 6, уур амьсгалын нөхцөл хүйтэвтэр хуурай, хуурайдуу, олон жилийн цэвдэг чулуулаг байхгүй, зөвхөн улирлын хөлдөлт гэсэлттэй гүний усны төвшин доор учир барилгад нөлөөлөхгүй, гадаргын хэвгий гол төлөв 0-30, гадаргын хэрчигдлийн шигүү нэн бага 1 км/км², уруй болон элсний нөлөө байхгүй зэргийг харгалзан эдгээр үзүүлэлтээрээ хамгийн бага балл ногдож байгаа учраас барилгажилтад байгалийн нөхцөлийн хувьд

тохиромжтой муж юм. Хоёрдугаар муж: Гадаргын хувьд цав толгодын ба бэсрэг, нам уулын хэв шинжит хотгор гүдгэр зонхилно. Инженерийн барилга байгууламжид нөлөөлөх байгалийн хүчин зүйлүүд: газар хөдлөлийн балл 7, уур амьсгалын нөхцөл хүйтэн хуурайдуу, олон жилийн цэвдэг чулуулаг, ховор алаг цоог тархалттай, гүний усны төвшин гол төлөв доор, гадаргын хэвгий 3-60, гадаргын хэрчигдлийн шигүү 2-3 км/км² байна.

Зураг 14. Барилгын уур амьсгалын мужлалт



Тайлбар:
Судалгааны
хүрээнд
боловсруулав

1.5. Газар ашиглалтын байдал

Газрын нэгдмэл сангийн ангиллын 2019 оны тайлангаас судалгааны хамрах хүрээний 18926 км² газар нутгийн 101689.7 га газрыг тусгай хамгаалалтад авсан байна. Энэ ангиллын газрыг Хангайн нурууны байгалийн цогцолбор газар эзэлдэг.

Газрын тухай хуулийн 10-р зүйлд заасны дагуу үндсэн ангилал болон дэд ангиллаар газрын хэмжээг тооцлоо.

Хүснэгт 7. Судалгааны талбай газрын нэгдмэл сангийн ангилалаар

№	Үндсэн ангилал	Хамаарах газрын төрөл	Газрын хэмжээ /га/	Эзлэх хувь
1	Хөдөө аж ахуйн газар	Нийт	1672021.4	88.34
		Хадлан	13581.2	0.72
		Усалгаатай тариалан	12844.2	0.68
		Усалгаагүй тариалан	1335.3	0.07
		Атаршсан газар	51970.8	2.75
		ХАА-н барилга байгууламж	3320	0.18
		Бэлчээр	1588969.9	83.96
2	Хот, тосгон болон суурин газар	Нийт	5730.25	0.3
		Барилга байгууламжийн газар	80.4	0.004
		Суурьшлын газар	393.6	0.02
		Үйлдвэрийн газар	23.44	0.0012
		Нийтийн эдэлбэрийн газар	4950.2	0.26
		Амралт, аялал жуулчлалын газар	25.01	0.0013
		Уурхайн газар	257.6	0.014
3	Зам, шугам сүлжээний газар	Нийт	10885.7	0.58
		Авто замын газар	8502.6	0.45
		Шугам сүлжээний газар	2383.1	0.13
4	Ойн сан бүхий	Ой модоор бүрхэгдсэн газар	93331.4	4.93
5	Усан сан бүхий	Горхи, булаг,	8958.74	0.47
6	Тусгай хэрэгцээний газар	Нийт	101692.37	5.37
		Улсын тусгай хамгаалалттай газар	101689.7	5.37
		Шинжлэх ухаан, технологийн сорилт туршилт болон байгаль орчин, цаг агаарын төлөв байдлын байнгын ажиглалтын талбай	2.67	0.0001
	Нийт		1892621	100

*- нутаг дэвсгэрийн 5.37 хувь нь тусгай хамгаалалттай газар нутагт багтдаг.

Хөдөө аж ахуйн газар. Тус газар нь 1672021 га буюу нутаг дэвсгэрийн 88.34 хувийг эзэлж байна. Энэ ангиллын ихэнх хэсэг нь бэлчээрийн газар эзлэх ба хадлангийн талбай 0.7 хувийг эзэлж байна. Харин тариалангийн талбай 0.7 хувь,

ХАА-н зориулалттай барилга байгууламжид бэлчээр дэх худгууд ихэвчлэн орсон бөгөөд 0.18 хувь, атаршсан газар нэлээд хувийг буюу 2.7 хувийг эзэлж байна.

Хот, тосгон, бусад суурины газар. Тус ангиллын газар нь 5730.25 га буюу нутаг дэвсгэрийн 0.3 хувийг эзэлж байна. Энэ ангиллын газарт барилга байгууламжийн дэвсгэр газар 0.004 хувийг, суурьшлын газар 0.02 хувийг, үйлдвэрийн газар 0.0012 хувийг, амралт, аялал жуулчлалын газар 0.0013 хувийг, уурхайн газар 0.014 хувийг, нийтийн эдэлбэр газар 0.26 хувийг тус тус эзэлж байна.

Зам, шугам сүлжээний газар. Тус ангиллын газар нь 10885.7 га буюу нутаг дэвсгэрийн 0.58 хувийг эзэлж байна. Хот хоорондын авто замууд энэ ангилалд хамрагдаж авто замын газар 8502.6 га эзэлж байна. Тухайн нутаг дэвсгэрт төмөр замын газар, агаарын замын ангиллын газар, усан тээврийн буудлын ангиллын газар байхгүй. Шугам сүлжээний газарт 2383.1 га газрыг хамарч байна.

Ойн сан бүхий газар. Тус ангиллын газар нь 93331.4 га буюу нутаг дэвсгэрийн 4.93 хувийг эзлэж байна. Нутаг дэвсгэрийн хойд болон баруун урд тал ойтой. Ойн талбайг гаргахдаа байр зүйн зурагт тэмдэглэгдсэн ой модоор бүрхэгдсэн газраар нь тооцлоо. Харин ой модыг огтолсон талбай, мод үржүүлгийн газрыг нарийвчлан тооцоогүй болно.

Усны сан бүхий газар. Тус ангиллын газар нь 8958.74 га буюу нутаг дэвсгэрийн 0.47 хувийг эзэлж байна. Орхон гол түүний цутгал голууд, нуур цөөрөм булаг шанд багтаж байна.

Улсын тусгай хэрэгцээний газар. Хангайн нурууны байгалийн цогцолбор газрыг Монгол Улсын Их Хурлын 1996 оны 43 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар байгалийн цогцолборт газрын ангилалд оруулж хил заагийг нь баталсан байдаг. Тус ангиллын газар нь 101689.7 га буюу нутаг дэвсгэрийн 5.37 хувийг эзэлж байна.


Хүснэгт 8. Газар нутгийн талбай, га

№	Газар нутаг	Хэмжээ /га/	Эзлэх хувь
1	Судалгааны хамрах хүрээ	1892621	100
2	Байгалийн нөөц газар	4444.78	0.23
3	Байгалийн цогцолбор газар	168942.26	8.93
4	Орхоны хөндий	92717.98	4.9
5	Хангайн нуруу	38685.54	2.04
6	Хөгнө тарна	37538.74	1.98

Эх сурвалж: Газрын нэгдмэл сан


Зураг 15. Газар ашиглалт

Тайлбар: Урьдчилсан судалгааны хүрээнд тоймлон гаргаав



1.6. Бэлчээрийн даац, ашиглалт


Зураг 16. Бэлчээрийн даац



Эх сурвалж: ХАНСХЕТ 2020, Бэлчээрийн даац, түүний ашиглалт

Сүүлийн жилүүдийн бэлчээрийн газрын доройтол, бэлчээрийн даац, талхлагдлын судалгаануудаас харахад Монгол орны бэлчээрийн доройтолд ихээр нэрвэгдсэн аймгуудад Өвөрхангай, Архангай, аймгууд багтаж байна. Орхоны хөндийн бэлчээрийн газрын төрх байдал, бэлчээрийн бүслүүрийн хэв шинж нь ойт хээр, хээрийн бүсүүдэд хамаарагдана. Малын тоо ихэссэн, малчдын отор нүүдлийн тоо болон зай багасах, Орхон голын хөндийг дагасан малын хэт бөөгнөрөл бусад шалтгаануудтай холбоотойгоор бэлчээрийн газар ихээр доройтсон. Ус цаг уур орчны судалгаа, мэдээллийн хүрээлэнгээс 2020 оны бэлчээрийн даацын судалгааг багийн нутгаар улсын хэмжээнд боловсруулахад Орхоны хөндийд байгуулах шинэ хот, суурьшлын бүсийн нутагт хамаарагдсан 3

аймгийн 8 сумын 70 багаас бэлчээр хүрэлцээтэй 6 баг, бэлчээрийн нөөцтэй 16 баг, даац 1-3 дахин хэтэрсэн 26 баг, даац 3-5 дахин хэтэрсэн 10 баг, даац олон дахин хэтэрсэн 12 баг байна. Үүнээс дүгнэхэд 8 сумдын нутгийн 68.5 хувь нь бэлчээрийн даац хэтрэлттэй, 31.5 хувь нь бэлчээрийн даац хэтрээгүй байна.



Зураг 17. Бэлчээрийн даац, багаар

Эх сурвалж: ХАНСХЕТ 2020, Бэлчээрийн даац, түүний ашиглалт, талхагдлын үнэлгээ

Судалгааны хил заагт багтсан 8 сумдын нийт малын тоо 2 530 000, хонин толгойд шилжүүлбэл 4 224 366 мянган толгой мал байна. Сумдын газар нутгийн хэмжээнд харьцуулж үзэхэд 1 га газарт 265 хонин толгой мал ногдож байна.

1.6. Нийгэм эдийн засгийн судалгаа

Орхоны хөндийд Архангай аймгийн 4, Булган аймгийн 3, Өвөрхангай аймгийн 1, нийт 8 сумын нутаг дэвсгэр хамаарч байна. 2019 оны Монгол Улсад оршин суугаа хүн амын 1.1 хувь энэ бүс нутагт ногдож байна. Эдгээр сумдын нийт хүн амын 38 хувь буюу 14000 орчим нь сумын төв суурин газар амьдарч байна. Хүн амын өсөлтийн хувьд 2040 он хүртэл жилд дунджаар 0,6 хувийн өсөлттэй байна.

Угсаатан, ястны хувьд халх, өөлд ястан зонхилдог. Архангай аймгийн Өлзийт сумын ард иргэдийн 84 хувь нь өөлд, бусад сумдын хувьд 98,4-99,6 хувь халх ястан байна.

Хүснэгт 9. Хүн амын тоо, оноор

№	Аймаг	Сум	2015	2016	2017	2018	2019	2020	2030 он			2040 он		
									Бүгд	Төв	Хөдөө	Бүг	Төв	Хөдөө
1	Архангай	Өгийнуур	3011	3131	3185	3213	3099	3127	3254	626	2628	3400	654	2746
2		Өлзийт	3301	3347	3383	3213	3414	3417	3890	938	2952	4412	1064	3348
3		Хашаат	3171	3213	3232	3261	3190	3212	3130	745	2385	3084	734	2350
4		Хотонт	4221	4284	4365	4380	4325	4370	4538	1255	3283	4741	1311	3430
5	Булган	Гурванбулаг	3129	3176	3219	3289	3168	3278	3541	635	2906	3918	703	3215
6	Булган	Могод	2671	2701	2729	2711	2643	2660	2802	494	2308	2955	521	2434
7	Булган	Сайхан	3561	3648	3662	3561	3501	3550	3577	713	2864	3649	728	2921
8	Өвөрхангай	Хархорин	12045	12405	12516	12499	12026	12256	12723	9119	3604	13392	9598	3794
9	Нийт		35110	35905	36291	36368	35882	35329	35910	14525	22930	39551	15313	24238

Эх сурвалж: ХАНСХЕТ 2020, Хүн амын хэтийн тооцоо, Үндэсний статистикийн хороо

Хүн амын хамгийн их нягшилтай сум нь Хархорин 5.4, хамгийн бага нь Могод 0.9, дунджаар 1.9 байна.

Хүснэгт 10. Хүн амын нягтшил

№	Аймаг	Сум	2020	Нутаг дэвсгэр	Хүн амын нягтшил
1	Архангай	Өгийнуур	3099	1686.48	1.8
2	Архангай	Өлзийт	3417	1720.37	2.0
3	Архангай	Хашаат	3212	2585.24	1.2
4	Архангай	Хотонт	4370	2417.40	1.8
5	Булган	Гурванбулаг	3278	2686.11	1.2
6	Булган	Могод	2660	2820.47	0.9
7	Булган	Сайхан	3590	2772.76	1.3
8	Өвөрхангай	Хархорин	12256	2241.16	5.4
9	Нийт		35329	18929.99	1.9

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, 2020

Сумдад гол ажил олгогч нь төсвийн байгууллага буюу сургууль, цэцэрлэг, соёлын төв, эмнэлэг, нутгийн захиргааны байгууллагын ажиллагсад байна. Орхоны хөндийд байрлах Архангай аймгийн Өгийнуур, Өлзийт, Хотонт, Хашаат, Булган аймгийн Могод, Гурванбулаг, Сайхан, Өвөрхангай аймгийн Хархорин гэсэн 8 сумын 15926 км² нутаг дэвсгэрт нийт 2020 оны үзүүлэлтээр 45 багийн 10,660 өрхөд 35,910 хүн амьдарч байна. Үүнээс Өвөрхангай аймгийн Хархорин сум 12256 хүн амын тоогоор 8-н сумдаас 1-рт, Булган аймгийн Могод сум 2660 хүн амын тоогоор 8-рт орж байна. / хүснэгт 10/

1.6.1. Засаг захиргаа, бүлэг суурингийн тогтолцоо

Орхоны хөндийд байрлах Архангай аймгийн Өгийнуур, Өлзийт, Хотонт, Хашаат, Булган аймгийн Могод, Гурванбулаг, Сайхан, Өвөрхангай аймгийн Хархорин гэсэн 8 сум, 46 баг хамрагдаж байна. Дэд бүтцийн яам “Хот байгуулалт” ТӨҮГ-ын боловсруулсан “Нутагшилт хөгжлийн ерөнхий төсөл”-ийн Бүлэг суурингийн тогтолцоогоор Бүлэг суурингийн тогтолцооны хувьд “Хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл”-ийн ажлын хүрээнд бүлэг суурингийн төвөөр Өвөрхангай аймгийн Хархорин сум, Архангай аймгийн Хотонт сум тус тус багтаж байна.

Хүснэгт 11. Бүлэг суурингийн төв

Аймаг	№	Бүлэг суурингийн төв	Бүлгийн сумын нэр
Архангай	1	Өгийнуур	1. Хашаат
			2. Өлзийт
			3. Батцэнгэл
			4. Хотонт
Булган	2	Булган	1. Орхон
			2. Бугат
			3. Сайхан
	3	Хишиг-Өндөр	1. Бүрэгхангай
			2. Могод
	4	Дашинчилэн	1. Баяннуур
			2. Гурванбулаг
Өвөрхангай	5	Хархорин	3. Рашаант
			1. Бат-Өлзий
			2. Хужирт

Эх сурвалж: Алсын хараа-2050

Хүснэгт 12. Бүлэг суурингийн төв

Аймаг	№	Бүлэг суурингийн төв	Бүлгийн сумын нэр
Архангай	1	Хотонт	1. Хашаат
			2. Өлзийт
			3. Өгийнуур
Булган	2	Булган хот Аймгийн төв	1. Орхон
			2. Бугат
			3. Сайхан /Сайхан овоо/
	3	Хишиг-Өндөр	1. Бүрэгхангай
			2. Могод
	4	Дашинчилэн	1. Баяннуур
			2. Гурванбулаг
Өвөрхангай	5	Хархорин хот Бүсийн тулгуур төв	3. Рашаант
			1. Бат-Өлзий
			2. Хужирт

Эх сурвалж: Хот байгуулалт ТӨҮГ, НХЕТ-Бүлэг суурингийн тогтолцоо, 2004

Хүснэгт 13. Нийгэм эдийн засгийн байдал

№	2020 он	Хотонт	Хашаат	Өгийнуур	Өлзийт	Могод	Гурванбулаг	Сайхан	Хархорин	Нийт
1	Өрхийн тоо	1284	902	925	1077	831	946	1077	3553	10595
2	Хүн амын тоо	4325	3181	3099	3386	2677	3289	3556	12256	23513
3	Төвийн хүн амын тоо	1185	750	650	803	450	577	723	8472	13610
4	Малын тоо	398710	372300	324400	353200	329596	326638	373702	296.22	2478546
5	Малчин өрхийн тоо	920	631	697	609	247	521	812	1017	4437
6	Малчдын тоо	1520	1051	1170	943	1037	903	1408	1803	8032
7	Багийн тоо	6	5	5	5	5	6	6	8	46
8	Төсвийн орлого (мян. төг)	265.3	270.2	1695	1265	77.9	1737	143.9	4212.7	9667
9	Төсвийн зарлага (мян. төг)	265.3	243.03	1244.8	1282	67.5	1737	327	4212.7	9379.33
10	ААНБ-н тоо	25	15	26	21	24	31	22	73	227

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, 2020

1.6.2. Аж үйлдвэр, үйлчилгээ, хөдөлмөрийн зах зээл

Монгол улс мал аж ахуйн гаралтай түүхий эд боловсруулах хөнгөн, хүнсний үйлдвэрийг давуутай хөгжүүлэхэд гол анхаарлаа чиглүүлж байсны зэрэгцээ байгалийн түүхий эдийн нөөцийг ашиглах, түлш эрчим хүч, уул уурхайн үйлдвэрийг түлхүү хөгжүүлэх зорилт дэвшүүлэн хэрэгжүүлж эхэлсэн. Орхоны хөндийд байрлах Архангай аймгийн Өгийнуур, Өлзийт, Хотонт, Хашаат, Булган аймгийн Могод, Гурванбулаг, Сайхан, Өвөрхангай аймгийн Хархорин сумд нь хөдөө аж ахуйд тулгуурласан мал аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэлд түшиглэн үйлдвэрлэл эрхэлдэг.

Архангай аймаг Өгийнуур: Сумын хэмжээнд нийт 26 аж ахуйн нэгж байгууллага 437.78 сая төгрөгийн борлуулалтын орлогын үйл ажиллагаа явуулж, улсад 8.59 сая, аймагт 3.98 сая, орон нутагт 0.66 сая нийт 9.65 сая төгрөгийн татвар төвлөрүүлж байна. 8 нэрийн хүнсний нийт 18 дэлгүүртэйгээс гадна 1 талх нарийн боовны цех, ноосны үйлдвэр, 6 цайны газар, 2 зочид буудал, үсчин, оёдол цех үйл ажиллагаа тогтмол үйл ажиллагаагаа явуулж, ажлын байр бий болгож байна. “Ногоон-Ази” ТББ нь сумын төвийн ойн зурвас бий болгохоор 20 гаруй хүнийг ажлын байраар ханган ажиллаж байна.

Архангай аймаг Өлзийт сум: Эдийн засгийн бүтцийн 18,4 хувийг аж үйлдвэрийн салбар бүрдүүлж байна. Сумын хэмжээнд нийт 21 аж ахуйн нэгж байгууллага 437.78 сая төгрөгийн борлуулалтын орлогын үйл ажиллагаа явуулж, улсад 8.59 сая, аймагт 3.98 сая, орон нутагт 0.66 сая нийт 9.65 сая төгрөгийн татвар төвлөрүүлж байна.

Архангай аймаг Хотонт сум: Эдийн засгийн бүтцийн 10 хувийг аж үйлдвэрийн салбар бүрдүүлж байна. Сумын хэмжээнд нийт 25 аж ахуйн нэгж байгууллага үйл ажиллагаа явуулж улсад 300,7 сая, аймагт 98.8 сая, орон нутагт 104.5 сая нийт 504.2 сая төгрөгийн татвар төвлөрүүлж байна. Нийт 25 аж ахуйн нэгжтэй үйл ажиллагаа явуулж байгаа нь бусад 3 сумаасаа илүү их ажлын байр бий болгож байна. Сумын гаралтай модны зах, 12 хүнсний дэлгүүр, цагаан идээний цех үйл ажиллагаа явуулж байна. Орон нутгийн хөгжлийн сангаар “Худалдааны төв” барьсан бөгөөд “Артхан” зочид буудал 2019 онд ашиглалтад орсон.

Архангай аймаг Хашаат сум: Эдийн засгийн бүтцийн 2 хувийг аж үйлдвэрийн салбар бүрдүүлж байна. Сумын хэмжээнд нийт 15 аж ахуйн нэгж байгууллага үйл ажиллагаа явуулж байна. Тус суманд “Ган шургуулга” ХХК, “Ган бэрх” ХХК нь худалдаа үйлчилгээний чиглэлээр, “Хашаат Баян” ХХК нь эмийн худалдаа, “Багд” нөхөрлөл мал эрүүлжүүлэх чиглэлээр мөн “Таван сан” хоршоо нь мал эрүүлжүүлэх чиглэлээр “Хашаат лүн” хоршоо нь худалдаа үйлчилгээ барилгын материал болох блок үйлдвэрлэлийн чиглэлээр эрчимтэй ажиллаж сумын эдийн засгийн бүтцэд томоохон нөлөө үзүүлж байна.

Булган аймаг Могод сум: Эдийн засгийн бүтцийн 8 хувийг аж үйлдвэрийн салбар бүрдүүлж байна. Сумын хэмжээнд нийт 24 аж ахуйн нэгж байгууллага үйл ажиллагаа явуулж улсад 16.3 сая төгрөг, аймагт 62.5 сая төгрөг, орон нутагт 79.9 сая төгрөг, нийт 144.0 сая төгрөгийн татвар төвлөрүүлжээ.

Булган аймаг Гурванбулаг сум: Эдийн засгийн бүтцийн 15 хувийг аж үйлдвэрийн салбар бүрдүүлж байна. Сумын хэмжээнд нийт 31 аж ахуйн нэгж байгууллага үйл ажиллагаа явуулж 199 сая төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж орон нутагт 0.9 сая төгрөгийн татвар төвлөрүүлж байна. Тус суманд блокны үйлдвэр, нарийн боовны цех, дугуй засвар, оёдол, мужаан, хүнс болон барааны жижиглэн худалдаа зэрэг аж ахуйн нэгжүүд үйл ажиллагаа явуулж байна.

Булган аймаг Сайхан сум: Эдийн засгийн бүтцийн 36,4 хувийг аж үйлдвэрийн салбар бүрдүүлж байна. Сумын хэмжээнд нийт 22 аж ахуйн нэгж, төсөвт байгууллага 8, банкны салбар 2, холбоо 1 үйл ажиллагаа явуулж байна. Орон нутгийн орлого 70,452,200 төгрөг. Улсын болон аймгийн төсөвд 113,701,100 төгрөг нийт 184,126,300 төгрөгний татвар бүрдүүлсэн байна. Сумын хэмжээнд нийт 22 аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулж байна. Хүнд үйлдвэрийн

хувьд тус суманд " Илчит металл" ХХК нүүрс олборлодог уул уурхайн аж ахуйтай. Ашигт малтмал нүүрсний гарц ихтэй. Айрагийн зах зээл өндөр зуны улиралд 30-40 тн айраг борлуулдаг. Рашаан сувилалын чиглэлээр 2 аж ахуйн нэгж, 9 иргэн үйл ажиллагаа явуулж байна.

Өвөрхангай аймаг Хархорин сум: Эдийн засгийн бүтцийн 15,3 хувийг аж үйлдвэрийн салбар бүрдүүлж байна. Сумын хэмжээнд 73 аж ахуйн нэгж байгууллага, 131 иргэн үйлдвэрлэл, 217 иргэн худалдаа үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулж 8,7 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж улсад 232,4 сая, аймагт 632,7 сая, орон нутагт 101,7 сая төгрөгийн татвар төвлөрүүлж байна. Суманд Өвөрхангай аймаг дахь сум дундын 2-р шүүх, сум Прокурорын газар, Хархорин дахь цагдаагийн хэлтэс, ШШГЕГ-ын харьяа ШШГАлба, Онцгой байдлын Гал Унтраах 45-р анги зэрэг хууль хяналтын байгууллагууд үйл ажиллагаа явуулж байна.Тус суманд ҮХААЯ-ны харьяа Тариалан Эрхлэлтийг Дэмжих Сан, "Хархорин" ХХК, "Зандан шоо-риса" ХХК, "АЗЗА-Хархорин" ХК, "Алтан тээрэм" ХХК зэрэг томоохон аж ахуйн нэгжүүд үйл ажиллагаа эрхэлж байгаа нь аж үйлдвэрийн бүтцэд томоохон нөлөө үзүүлж байна. "Хархорин" ХХК нь чацарганы томоохон аж ахуй эрхэлж байгаль орчинд таатай нөлөө үзүүлж, хөрсний элэгдэл, цөлжилтөөс хамгаалахын зэрэгцээ экологийн цэвэр бүтээгдэхүүнийг сумын иргэдэд нийлүүлж байна.

1.6.3. Хөдөө аж ахуй, газар тариалан*Хүснэгт 14. Малын төрөл, тоо, мян.тол, 2020*

Малын төрөл	Өгийнуур	Өлзийт	Хашаат	Хотонт	Хархорин	Гурванбулаг	Могод	Сайхан	Нийт
Адуу	15.02	19.61	16.74	29.39	23.67	17.71	24.97	33.87	180.984
Үхэр	15.35	15.37	14.45	27.84	21.54	10.85	14.73	15.59	135.705
Тэмээ	0.46	0.19	0.51	-	0.31	0.21	0.04	0.07	1.785
Хонь	184.46	187.99	198.3	155.11	154.84	183.02	201.63	171.83	1.437.19
Ямаа	99.77	101.45	107.28	107.92	95.86	121.23	73.4	67.68	774.596
Нийт	315.06	324.61	337.28	320.26	296.22	333.03	314.76	289.03	2.530.26

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Малын төрлөөр нь авч үзвэл нийт адуу - 180.984 мян.тол, үхэр - 135.705 мян. тол, тэмээ - 1.785 мян.тол, хонь - 1.437.19 мян.тол, ямаа - 774.596 мян.тол байна. Сайхан сум нь Булган аймагт малын тоогоор тэргүүлдэг.

Газар тариалан: Архангай аймгийн Өгийнуур сумын хэмжээнд нийт 1244 га-д газар тариалан эрхэлдэг. Үүнээс 3 га төмс, хүнсний ногоо, үр тариа 620 га, буудай 620 га талбайд тариалдаг байна. Өлзийт сумын хэмжээнд нийт 404 га-д газар тариалан эрхэлдэг. Үүнээс 46,9 хувьд нь төмс, хүнсний ногоо, 53,1 хувьд бусад таримал тариалж байна. Хашаат сумын хэмжээнд нийт 3 га-д газар тариалан эрхэлдэг. Үүнээс 66.6 хувьд нь төмс, хүнсний ногоо, 33.4 хувьд нь бусад таримал тариалж байна. Хотонт сумын хэмжээнд нийт 4010 га-д газар тариалан эрхэлдэг. Сумын хэмжээгээр жилд 33 га талбайд төмс, хүнсний ногоо, үр тариа 1970 га, тэжээлийн ургамал 18.7 га, буудай 1970 га, ногоон тэжээл 2.2 га талбайд тус тус тариалдаг байна.

Булган аймгийн Гурванбулаг сумын хэмжээнд нийт 7.4 га-д төмс, 10 га-д хүнсний ногоо тариалдаг. Атаршсан 8000 га тариан талбайтай. Жилд 300-320 тн төмс, 120-140 тн хүнсний ногоо хураан авдаг. Сайхан Сумын хэмжээнд нийт 11,6

га-д газар тариалан эрхэлдэг. Үүнээс 5.5 га буюу 47.4 хувьд нь төмс, хүнсний ногоо, 5 га буюу 43.1 нь жимс жимсгэнэ, чацаргана тариалдаг. 1.1 га буюу 9.5 хувь нь өнжөөсөн талбай байна. Могод сумын хэмжээнд нийт 11 га-д төмс хүнсний ногоо тариалдаг. Үүнээс 7 га-д нь төмс, 4 га-д хүнсний ногоо тариалж байна.

Өвөрхангай аймгийн Хархорин сумын хэмжээнд 18871 га эргэлтийн талбайтай жилд 5392 га талбайд үр тариа, 126 га талбайд төмс, 58 га талбайд хүнсний ногоо, овъёос 160 га, арвай 145 га, 100 га талбайд тэжээлийн ургамал тариалж 2820 тн үр тариа, 664,2 тн хүнсний ногоо, 937 тн төмс, 385 тн тэжээлийн ургамал хураан авч байна.

1.6.4. Уул уурхай

Уул уурхай, ашигт малтмалын хувьд Архангай аймгийн 4 сумдад үйл ажиллагаа явуулж байгаа уурхай байхгүй байна. Булган аймгийн Сайхан суманд "Илчит металл" ХХК нүүрс олборлодог бөгөөд уурхайн хүчин чадал 100 мян.тн/жил ашигт малтмал нүүрсний гарц ихтэй. Ажиллагсадын тоо 120 хүн байна. Мөн Сайхан-Овоогийн чулуун нүүрсний орд газар стратегийн ач холбогдолтой орд газарт орох боломжтой. Уул уурхайн үйлдвэрлэлийн орд болон хайгуулын MV-017695 төслийн Баян дүүрэх нь Гурванбулаг сум руу нүүрс нийлүүлдэг бөгөөд MV-014228 төслийн Эрээний ихэр уул, MV-011985 төслийн Сайхан уул зэрэг нь Сайхан сум руу нүүрс нийлүүлж байна. Могод сум, Өвөрхангай аймгийн Хархорин суманд томоохон уул уурхай байхгүй.

1.6.5. Аялал жуулчлал

Хархорин, Эрдэнэ зуу болон энэхүү хил заагт хамрагдаж байгаа 3 аймаг, найман сум (Хархорин, Хужирт, Өлзийт, Хотонт, Хашаат, Өгийнуур, Могод, Гурванбулаг, Сайхан)-ын аялал жуулчлалын нөөц нь Монгол орны бусад бүс нутгуудтай харьцуулахад илүү байна. Дэд бүтэц, жуулчдад үзүүлж буй үйлчилгээ, жуулчин хүлээн авах хүчин чадал, жуулчдын тоо, тус бүс нутагт аялал жуулчлалын үйлчилгээ үзүүлж байгаа компаниудын тоо зэргээрээ бусад аймаг, бүс нутгуудаас харьцангуй өндөр юм. Тус бүс нутагт дэлхий дахинаа хүлээн зөвшөөрөгдсөн Дэлхийн Өв-Орхоны Хөндийн Соёлын Дурсгалт Газар багтаж байгаа болон бага зайд аялал жуулчлалын бүтээгдэхүүн, жуулчдын сонирхлыг татах байгалийн үзэсгэлэнт газар, нүүдлийн соёлын өв нэгэн дор байгаа нь тус бүс нутгийг дотоодын төдийгүй олон улсын төвшинд илүү давуутай нөхцөлийг олгож байна.


Тухайн бүс нутаг нь олон төрлийн тусгай хамгаалалттай газрын огтлолцол дээр байрладаг. Тухайлбал UNESCO-ийн Дэлхийн Өвд бүртгэсэн гол газар нутгийн хил хязгаарын ихэнх нь энэ хэсэгт хамрагдах ба Орхоны хөндийн байгалийн цогцолбор газар зэргийг дурдаж болох юм. Мөн Монгол улсын аялал жуулчлалын "Босоо тэнхлэг" буюу Өмнөговь, Өвөрхангай, Архангай, Хөвсгөл гэсэн байгалийн бүс бүслүүрээрээ говь (жуулчдын хувьд үлэг гүрвэл, археологи, палеонтологийн үнэт олдворуудтай бүс), хээр тал (нүд алдам хээр тал энэ нь далайг санагдуулам байдаг талаар олон жуулчдын тэмдэглэлээс харж болно), хангай (халуун хүйтэн рашаан, эртний шашны болон түүхийн дурсгалт газрууд, Монгол улсын аялал жуулчлалын хөгжилд ихээхэн чухал нөлөө үзүүлнэ.

Орхоны хөндий нь өнө эртнээс бэлчээрийн мал аж ахуй эрхлэн амьдардаг нүүдэлчдийн соёлыг илтгэн харуулах хөдөлшгүй баримт, гэрч нотолгоо болсон булш хиргисүүр, ховор нандин хөшөө дурсгал, хадны дурсгал, бичээс археологийн зүйл бүрийн үнэ цэнт олдворууд зэрэг нэн баялаг соёлын өвтэй. Энд эртний Уйгур улс, Их Монгол улсын нийслэл Хар балгас, Хархорум хотуудын тууриуд, бурхны

шашны анхны төв Эрдэнэ Зуу, анхдугаар Богд Өндөр Гэгээн Занабазарын нямба бясалгалын орон Төвхөн, Шанхын Баруун хүрээ хийдүүд, Түрэгийн хаан Билгэ, түүний дүү Культегин жанжинд зориулж босгосон гэрэлт хөшөө зэрэг томоохон дурсгалууд, Хужиртын халуун рашаан, Хярууны халуун рашаан, Орхон гол гэх мэт гадаад, дотоодын аялал жуулчлалын үндсэн бүтээгдэхүүн бий.

Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 8 дугаар сарын 21-ний өдрийн 333 дугаар тогтоолоор батлагдсан “Төрөөс аялал жуулчлалыг хөгжүүлэх талаар баримтлах бодлого”-ийн 4.4.4. Орхоны хөндийн байгалийн цогцолборт газарт аялал жуулчлалын үндэсний парк бий болгох, 4.4.5. рашаан сувилалд түшиглэсэн эрүүл мэндийн аялал жуулчлалын бүсүүдийг хөгжүүлэх; талаар тусгагдсан.

Зураг 18. Аялал жуулчлалын гол чиглэл



Эх сурвалж: ХАНСХЕТ 2020, Аялал жуулчлалын судалгаа

1.7. Нийгмийн дэд бүтэц

1.7.1. Ерөнхий боловсролын сургууль


2019-2020 оны хичээлийн жилд Архангай аймгийн хэмжээнд ерөнхий боловсролын 33 сургууль сургалтын үйл ажиллагаа эрхэлж байна. Тэдгээрийн 90.9 хувь нь төрийн өмчийн, 9.1 хувь нь хувийн сургууль байна. Булган аймгийн хэмжээнд ерөнхий боловсролын 22 сургууль сургалтын үйл ажиллагаа эрхэлж байгаа бөгөөд бүгд төрийн өмчийн сургууль байна. Өвөрхангай аймгийн хэмжээнд ерөнхий боловсролын 31 сургууль сургалтын үйл ажиллагаа эрхэлж байгаа бөгөөд үүнээс төрийн өмчийн 30, төрийн бус өмчийн 1 сургууль байна.

Хүснэгт 15. ЕБС-ийн зарим тоон үзүүлэлт, 2020 оноор

№	Аймаг	Сум	Нийт хүн амын тоо	Одоо байгаа ЕБС-ийн төслийн хүчин чадал (суудлын тоогоор) 2019 оноор	ЕБС-ийн хүчин чадалын зөрүү	2020 он							
						ЕБС-д хамрагдаж байгаа суралцагчийн тоо	Бүлгийн тоо	Бүлэг дүүргэлт	Ангилал				Нийт ЕБС-ийн тоо
									Цогцолбор	Ахлах	Дунд	Бага	
1	Архангай	Өгийнуур	3,099	560	27	533	20	27		1			1
2		Өлзийт	3,386	320	-399	719	28	26		1			1
3		Хашаат	3,181	640	143	497	20	25		1			1
4		Хотонт	4,325	760	-35	795	34	23		1	1		2
5	Булган	Гурванбулаг	3,168	610	-25	635	27	24		1			1
6		Могод	2,643	450	97	353	14	25			1		1
7		Сайхан	3,501	440	-46	486	19	26		1			1
8	Өвөрхангай	Хархорин	12,026	2273	-212	2485	95	26	1	2			3

Эх сурвалж: БСШУСЯ-ны статистик мэдээ

Зураг 19. Ерөнхий боловсролын сургуулийн хүрэлцээ, хангамж



Эх сурвалж: БСШУСЯ-ны статистик мэдээ

Судалгаанаас гарсан үзүүлэлтэд дүн шинжилгээ хийхэд Хүн амын өсөлт, хот төлөвлөлтийн норм ба дүрэмтэй (Ерөнхий боловсролын сургуулийн 1 ээлжээр хичээллүүлэх) уялдуулан барилгын хүчин чадлаас 30% хэтэрсэн тохиолдолд өргөтгөж, 60% давсан үед шинээр сургууль төлөвлөх шаардлагатай дүгнэлт гарч байна.

Дээрх судалгаанаас үзвэл Өлзийт, Хархорин сургуулийн барилга шинээр барих, өргөтгөх шаардлагатай байна. суманд сургуулийн барилга шинээр төлөвлөх шаардлагатай, харин Хотонт сумдад сургуулийн барилгыг өргөтгөх шаардлагатай тооцоолол харагдаж байна.

Харин дотуур байрны хувьд Өгийнуур, Өлзийт сум 75, Хашаат сум 150, Хотонт сум 186 хүүхдийн хүчин чадалтай, Хархорин сум 150 хүүхдийн хүчин чадалтай, Гурванбулаг сум 60, Могод сум 80, Сайхан сум 205 хүүхдийн хүчин чадалтай байна.

1.7.2. Сургуулийн өмнөх боловсрол


2019-2020 оны хичээлийн жилд Архангай аймгийн хэмжээнд сургуулийн өмнөх боловсролын 35 цэцэрлэг сургалтын үйл ажиллагаа эрхэлж байна. Тэдгээрийн 97.1 хувь нь төрийн өмчийн, 2.9 хувь нь хувийн хэвшлийн цэцэрлэг байна. Булган аймгийн хэмжээнд сургуулийн өмнөх боловсролын 22 цэцэрлэг сургалтын үйл ажиллагаа эрхэлж байна. Тэдгээрийн 100 хувь (22) нь төрийн өмчийн цэцэрлэг байна. Өвөрхангай аймгийн хэмжээнд сургуулийн өмнөх боловсролын 42 цэцэрлэг сургалтын үйл ажиллагаа эрхэлж байна. Тэдгээрийн 90 хувь (38) нь төрийн өмчийн цэцэрлэг байна.

Хүснэгт 16. СӨБ-ын зарим тоон үзүүлэлтүүд, 2020 оноор

№	Аймаг	Сум	Нийт хүн амын тоо	Одоо байгаа СӨБ-ын төслийн хүчин чадал (суудлын тоогоор) 2020 оноор	2019-2020 он				
					Өргөтгөх шаардлагатай хүүхдийн орны тоо	СӨБ-д өдрөөр Суралцагчийн тоо	Бүлгийн тоо	Бүлэг дүүргэлт	Нийт СӨБ-ын тоо
1	Архангай	Өгийнуур	3,099	140	-114	140	8	32	1
2		Өлзийт	3,386	90	-229	194	8	40	1
3		Хашаат	3,181	120	-160	130	7	40	1
4		Хотонт	4,325	175	-117	208	10	29	2
5	Булган	Гурванбулаг	3,168	75	-150	128	10	23	1
6		Могод	2,643	100	-78	93	7	25	1
7		Сайхан	3,501	100	-65	104	5	33	1
8	Өвөрхангай	Хархорин	12,026	493	-486	578	22	45	5

Эх сурвалж: БСШУСЯ-ны статистик мэдээ

Зураг 21. Сургуулийн өмнөх боловсролын хүрэлцээ, хангамж



Эх сурвалж: БСШУСЯ-ны статистик мэдээ

Хүн амын өсөлт хурдацтай байгаа өнөө үед дээрх 4 сумдад одоо байгаа сургуулийн өмнөх боловсрол буюу цэцэрлэгийн хүчин чадал нь дутагдалтай, шинээр төлөвлөх буюу өргөтгөх шаардлагатай байна.

Архангай аймгийн сургуулийн өмнөх боловсролын (2-5 нас) насны хүн амын өсөлтийг авч үзэхэд Хашаат сумын сургуулийн өмнөх боловсролд хамрагдах насны хүн амын өсөлт бага зэрэг буурсан бол Өгийнуур, Өлзийт, Хотонт сумдын тогтвортой өсөлттэй байна. Булган аймгийн Гурванбулаг, Могод, Сайхан сумдад одоо байгаа сургуулийн өмнөх боловсрол буюу цэцэрлэгийн хүчин чадал нь дутагдалтай, шинээр төлөвлөх буюу өргөтгөх шаардлагатай байна. 2020 оны байдлаар дээрх 3 сумдын сургуулийн өмнөх боловсролын байгууллагуудын актлагдсан барилга байхгүй байна. Өвөрхангай аймгийн Хархорин суманд цэцэрлэгийн тоог нэмэгдүүлэх шаардлагатай байна.

1.7.3. Эрүүл мэндийн байгууллага

Хүснэгт 17. Эрүүл мэндийн байгууллага

№	Аймаг	Сумын нэр	Хүчин чадал	Ангилал	Ашиглалтад орсон хугацаа	Өргөтгөл	Шинээр барих шаардлагатай эсэх
1	Архангай	Хотонт	10 ор	ЭМТ	2010 он		+
2		Өгийнуур	10 ор	ЭМТ	2016 он		+
3		Өлзийт	10 ор	ЭМТ	1986 он	тогтмол урсгал засвар хийгдсэн	+
4		Хашаат	10 ор	ЭМТ	2009 он		+
5	Булган	Могод	7 ор	ЭМТ	1973 он		+
6		Гурванбулаг	10 ор	ЭМТ	2005 он		+
7		Сайхан	8 ор	ЭМТ	1986 он	2018 он	+
8	Өвөрхангай	Хархорин	80 ор	Нэгдсэн эмнэлэг	1997 он		+

Эх сурвалж: ЭМЯ-ны статистик мэдээ

Архангай аймгийн Өгийнуур суманд 10 орны хүчин чадалтай эрүүл мэндийн байгууллага үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд тус эмнэлгийн барилга 2016 онд

ашиглалтад орсон байна. Өлзийт суманд 10 орны хүчин чадалтай эрүүл мэндийн байгууллага үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд тус эмнэлгийн барилга 1986 онд ашиглалтад орсон. Тогтмол урсгал засвар хийгдсэн байна. Хашаат суманд мөн 10 орны хүчин чадалтай эрүүл мэндийн байгууллага үйл ажиллагаа явуулж байгаа ба эмнэлгийн барилга 2009 онд ашиглалтад орсон. Хотонт суманд мөн 10 орны хүчин чадалтай эрүүл мэндийн байгууллага үйл ажиллагаа явуулж байгаа ба эмнэлгийн барилга 2010 онд ашиглалтад орсон. Дээрх 4 сумын хүн амын тоо болон нормд заасан тоо хэмжээнд уялдуулан тооцож үзэхэд Өгийнуур, Хашаат суманд 16, Өлзийт суманд 18, Хотонт суманд 25 орны хүчин чадал дутагдалтай байна.

Булган аймгийн Гурванбулаг суманд 10 орны хүчин чадалтай эрүүл мэндийн байгууллага үйл ажиллагаа явуулж байна. Тус эмнэлгийн барилга 2005 онд ашиглалтад орсон ба 2018, 2020 онуудад засвар хийгдсэн. Могод суманд 7 орны хүчин чадалтай эрүүл мэндийн байгууллага үйл ажиллагаа явуулж байна. Тус эмнэлгийн барилга 1973 онд ашиглалтад орсон. 2019-2020 онд засвар хийгдсэн байна. Сайхан суманд 8 орны хүчин чадалтай эрүүл мэндийн байгууллага үйл ажиллагаа явуулж байгаа ба эмнэлгийн барилга 1986 онд ашиглалтад орсон. 2018 онд засвар хийгдсэн байна. Дээрх 3 сумын хүн амын тоо болон нормд заасан тоо хэмжээнд уялдуулан тооцож үзэхэд Гурванбулаг суманд 16, Могод суманд 15, Сайхан суманд 20 орны хүчин чадал дутагдалтай байна. Иймд өргөтгөх, шинээр эмнэлэг барих шаардлагатай байна.

Өвөрхангай аймгийн Хархорин суманд 80 орны хүчин чадалтай эрүүл мэндийн байгууллага үйл ажиллагаа явуулж байна. Тус эмнэлгийн барилга 1997 онд ашиглалтад орсон. Хүн амын тоо болон нормд заасан тоо хэмжээнд уялдуулан тооцож үзэхэд нэмэлт 20 орны хүчин чадал дутагдалтай байна. Иймд өргөтгөх, шинээр эмнэлэг барих шаардлагатай байна.

1.8. Зам тээвэр

Зам харилцааны хувьд олон улсын АН-32[1] буюу Хашаат сумын Тарнын гүүрнээс Хархорин хүртэлх А0601, Хархориноос Цэцэрлэг хот хүртэлх А0602 дугаартай улсын чанартай хатуу хучилттай авто зам өнгөрдөг. Энэхүү зам нь Хашаат, Хотонт сумдыг Улаанбаатар хоттой холбодог. Мөн Мянганы замын хэвтээ тэнхлэгийн үргэлжлэл болох Орхоны гүүрнээс Батцэнгэл сумыг дайраад Ихтамир сумын төвд А0603 дугаартай хатуу хучилттай авто замтай холбох зам, гүүрийн ажил хийгдэж байна. Архангай аймгийн Өлзийт сумын газар нутгаар Мянганы замын хэвтээ тэнхлэгийн 35 км хатуу хучилттай авто зам дайран өнгөрдөг. Багууд хоорондоо шороон замаар холбогдсон. Мянганы замын хэвтээ тэнхлэгийн 318-р тэмдэгтийг сумын төвтэй холбох 220 км хатуу хучилттай авто зам баригдах ажил эхэлсэн.

Хүснэгт 18. Дэд бүтцэд холбогдсон байдал


№	Аймаг	Сумын нэр	Авто зам	Эрчим хүч
1	Архангай	Хотонт	A0602 Нийслэлтэй холбосон улсын чанартай 495 км урт авто замын нэг хэсэг дайран өнгөрдөг.	ТЭХС-д холбогдсон
2		Өгийнуур	Мянганы зам хүртэл 20 км	ТЭХС-д холбогдсон
3		Өлзийт	Мянганы зам хүртэл 35 км	ТЭХС-д холбогдсон
4		Хашаат	A0601 зам хүртэл 28 км	ТЭХС-д холбогдсон
5	Булган	Могод	Мянганы замын хэвтээ тэнхлэгийн хатуу хучилттай зам 11 км урттайгаар сумын нутгаар дайран өнгөрдөг.	ТЭХС-д холбогдсон
6		Гурванбулаг	Дашинчилэнгийн чиглэлийн 55 км хатуу хучилттай авто зам хөндлөн дайран өнгөрдөг.	ТЭХС-д холбогдсон
7		Сайхан	Булган Мөрөнгийн чиглэлийн хэвтээ тэнхлэгийн асфальтан хар замаас 54 км, төв хэвтээ тэнхлэгийн замаас 105 км зайд байрлаж байна.	ТЭХС-д холбогдсон
8	Өвөрхангай	Хархорин	Мянганы зам хүртэл 114км.	ТЭХС-д холбогдсон

Эх сурвалж: ХАНСХЕТ 2020, Зам тээврийн сүлжээ болон тээвэр логиستيкийн хэтийн төлөв

1.9. Инженерийн дэд бүтэц

Өгийнуур, Хотонт, Гурванбулаг зэрэг сумд нэг эх үүсвэрийн 35 кВ-ын ЦДАШ ашиглаж байгаа бол Өлзийт, Могод нэг эх үүсвэрийн 35 кВ-ын ЦДАШ ашиглаж байна. Сайхан сумын хувьд 10 кВ-ын ЦДАШ ашиглаж байна. Хархорин сум 35 кВ-ын ЦДАШ болон 110 кВ-ын ЦДАШ ашиглаж байна. Эрчим хүчний эх үүсвэрийн хувьд “Төвийн эрчим хүчний систем”-д холбогдсон байна.

Зураг 22. Эрчим хүч



Эрчим хүчний хэрэглээ

Эх сурвалж:
ХАНСХЕТ 2020,

Хүснэгт 19. Цахилгаан хангамж, сумаар

№	Монгол улсын аймаг сумын жагсаалт		Нийт хүн ам, 2018	Төвийн хүн ам	Хөдөөгийн хүн ам	Монгол улсын цахилгаан хангамж		
	Аймгийн нэр	Сумын нэр				Дэд станцын тоо	Дэд станцын чадал, хүчдэл кВА. кВ	ЦДАШ-ын чиглэл, хүчдэл кВ
1	Булган	Могод	2711	478	2233	1	35/0.4	Хишиг-өндөр 35
2		Сайхан	3561	710	2851	1	10/0.4	Сайхан-овоо 10
3		Гурванбулаг	3289	590	2699	1	35/0.4	Архангайн Хашаат 35
4	Архангай	Өгийнуур	3213	618	2595	1	35/0.4	Хотонт 35
5		Өлзийт	2474	1002	1472	1	35/0.4	Есөнзүйл 35
6		Хашаат	3261	776	2485	1	35/0.4	ӨХ Хархорин 35
7		Хотонт	4380	1211	3169	1	35/0.4	ӨХ Хархорин 35
8	Өвөрхангай	Хархорин	12499	8958	3541	1	2х 10000 110/35/10	Булган 110

Эх сурвалж: ХАНСХЕТ 2020, Инженерийн дэд бүтцийн хангамжийн хэтийн төлөв

Хүснэгт 20. Дулаан хангамж, сумаар

№	Сумын нэр	Хүн амын тоо			Нэгдсэн халаалтын эх үүсвэртэй эсэх	Хэрэгцээний халуун усны шугам /м/		Бохир ус татан зайлуулах шугам /м/		Бага оворын халаалтын зуух	Нийтийн халуун устай эсэх
		Нийт	Төв	Хөдөө		нийт урт	Ашиглалтын төлөв байдал	нийт урт	Холбогдсон байгууллага өрхий тоо	Хүчин чадал /кВт/	
1	Гурванбулаг	3289	577	2712	Үүсвэртэй	-		-	-	2 МВт	байна
2	Могод	2677	450	2227	Үүсвэртэй	-		-	-	1.6 МВт	байна
3	Сайхан	3556	723	2833	Үүсвэртэй	-		-	-	2 МВт	байна
4	Хотонт	5510	1185	4325	ЗДТГ Сургууль Цагдаагийн кобан сургуулийн халаалтын зуухнаас	-		310	Байгууллага бүр бие даасан цооногтой	1324	1
5	Хашаат	3931	750	3181	-	-		180	Байгууллага бүр бие даасан цооногтой	1381	1
6	Өгийнуур	3749	650	3099	-	-		55	Байгууллага бүр бие даасан цооногтой	832	1
7	Өлзийт	4199	803	3396	+	-		55	Байгууллага бүр бие даасан цооногтой	2800	1
8	Хархорин	12290	8472	3818	нэгдсэн халаалтын 7 зуухтай 6526 квт	-		12 880	207 айл өрх, 46 ААНБ	Нийт 14 зуух. 100 квт-с доош	3ш хэвийн ажиллаж байгаа

Эх сурвалж: ХАНСХЕТ 2020, Инженерийн дэд бүтцийн хангамжийн хэтийн төлөв Хүснэгт 21. Ус

хангамж, сумаар


Эх сурвалж: ХАНСХЕТ 2020, Инженерийн дэд бүтцийн хангамжийн хэтийн төлөв

№	Сумын нэр	Хүн амын тоо			Нэгдсэн ундны усны баталгаат эх үүсвэртэй эсэх		Цэвэрлэх байгууламжтай эсэх		Ус хангамжийн шугам сүлжээ /м/	
		Нийт	Төв	Хөдөө	Эх үүсвэрийн нэр, байршил	Ашиглалтын төлөв байдал /тайлбар/	Хүчин чадал /м3/	Ашиглалтын төлөв байдал /Тайлбар/	нийт урт	Холбогдсон байгууллага өрхий тоо
1	Гурванбулаг	3289	577	2712	Үгүй	Үгүй	-	-	Үгүй	Үгүй
2	Могод	2677	450	2227	Үгүй	Үгүй	-	-	1184	ЗДТГ, Сургууль, цэцэрлэг, соёлын төв, Эмнэлэг, Хаан банк, Дотуур байр
3	Сайхан	3556	723	2833	100 м3	2019 онд ашиглалтад орсон	-	-	2152	Ус түгээх ухаалаг худаг 3ш, цэцэрлэг, эмнэлэг, дотуур байр, хаан банк
4	Хотонт	5510	1185	4325	Их булгийн гүний худаг	Сайн	-	-	927	Барилга тус бүр гүний худагтай
5	Хашаат	3931	750	3181	гүний худаг	Сайн	-	-	350	Барилга тус бүр гүний худагтай
6	Өгийнуур	3749	650	3099	гүний худаг-1ш	Сайн	-	-	495	Барилга тус бүр гүний худагтай
7	Өлзийт	4199	803	3396	гүний худаг	Сайн	-	-	1630	Төрийн байгууллага-6 өрхийн тоо-22
8	Хархорин	12290	8472	3818	8-р баг Орхон голын 1.2-р дэнжийн	2012 онд ашиглалтанд орсон хэвийн	360 м3	2012 онд ашиглалтанд орсон хэвийн	32660	234 айл өрх, 46 ААНБ

БҮЛЭГ 2. НУТАГ ДЭВСГЭРИЙН ХОТ БАЙГУУЛАЛТЫН ИЖ БҮРЭН ҮНЭЛГЭЭ

“Хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл”-ийг боловсруулах ажлын хүрээнд нутаг дэвсгэрийн болоод хот суурины төвшинд хот байгуулалтын иж бүрэн үнэлгээний ажлыг “Ланд Овнер” ХХК боловсруулсан бөгөөд тус хот байгуулалтын иж бүрэн үнэлгээний зураглалын өгөгдөлд тулгуурлан Орхоны хөндийн хот байгуулалтын иж бүрэн үнэлгээг хийж гүйцэтгэлээ.

Зураг 23. Нутаг дэвсгэрийн хот байгуулалтын иж бүрэн үнэлгээ




Эх
сурвалж:
ХАНСХЕТ
2020, Нутаг
дэвсгэрийн
түвшний
ХБИБҮнэлгээ

Уг үнэлгээнд шинээр байгуулах хот суурины дэвсгэр газарт хот байгуулалтын иж бүрэн үнэлгээ өгөх аргачилсан зааврын байгалийн нөхцөл нөөцийн төвшинд барилгажилтын уур амьсгал, хөрс болон усны бохирдол, газрын

гадаргын налуу, цэвдгийн тархалт, газар чичирхийлэл, инженер геологи, сэргээгдэх эрчим хүчний нөөц, усан хангамж, зэрэг шалгуур үзүүлэлтүүдээр үнэлэхэд нэн тохиромжгүй 249.7 км², тохиромжгүй 1857.4 км², хязгаарлагдмал тохиромжтой 10933 км², тохиромжтой 5886 км² талбай хамаарагдаж байгаа бол нэн тохиромжтой ангилалд багтсан талбай байхгүй гэсэн үр дүн гарлаа. Тохиромжтой болон хязгаарлагдмал тохиромжтой ангилалд голын хөндий, нам тэгш газар, уг бүс нутгийн баруун болон төвийн хэсгээр багтсан бол тохиромжгүй болон нэн тохиромжгүй ангилалд өндөр уулын бүслүүр, гадаргын өндөржилт их, уулархаг, газар хамаарагдаж байна.

Зураг 24. Хот байгуулалтын иж бүрэн үнэлгээ, талбайгаар, км²



Эх сурвалж: ХАНСХЕТ 2020, Нутаг дэвсгэрийн түвшний ХБИБҮнэлгээ

ДҮГНЭЛТ

Ус хангамжийн одоогийн байдлын үнэлгээг баталгаат ундны эх үүсвэртэй, ус хангамжийн шугам сүлжээнд холбогдсон байдал, ундны усны чанарын үзүүлэлт зэргийг тооцон үзэж гаргахад Архангай аймгийн Хашаат, Өвөрхангай аймгийн Гурванбулаг сум нь дунд зэргийн усны хэрэгцээтэй үйлдвэр байгуулж болох нутаг дэвсгэрт хамаарагдаж байгаа бол Архангай аймгийн Хашаат сум төв, суурин газрын ус хангамжийн батлагдсан орд ба нөөцийн хэмжээ $776.9 \text{ м}^3/\text{хоног}$ байгаа бол Өвөрхангай аймгийн Хархорин сум $7344.0 \text{ м}^3/\text{хоног}$ байна. Мөн ус хангамжийн системд холбогдсон төв, суурин газар, бохир усны цэвэрлэх байгууламжтай төв, суурин газарт усны хэрэгцээ ихтэй үйлдвэр байгуулж болох нутаг дэвсгэрт хамаарагдаж байна. Бусад 5 сумын хувьд усны хэрэгцээ ихтэй үйлдвэр байгуулж болох нутаг дэвсгэрт багтаж байна. Ус хангамжийн түвшин нэн өндөр төв, суурин газарт Өвөрхангай аймгийн Хархорин сум орж байна.

АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ

ХАНСХЕТ,(2020) Бэлчээрийн даац, түүний ашиглалт, талхагдлын үнэлгээ.
Улаанбаатар.

ХАНСХЕТ-ийн хүн амын хэтийн тооцоо (2020). Улаанбаатар

ШУА-ийн Одон орон геофизикийн судалгааны хүрээлэн (2020). Улаанбаатар

Үндэсний статистикийн хороо (2020) . Улаанбаатар

ХАНСХЕТ-ийн орон нутгийн судалгаа (2020) . Улаанбаатар

Ус цаг уур орчны судалгаа мэдээллийн хүрээлэн (2020) . Улаанбаатар

ХАНСХЕТ-ийн Бэлчээрийн багтаамж түүний ашиглалт, талхагдлын үнэлгээ (2020)
Улаанбаатар.

БСШУСЯ-ны статистик мэдээ (2020) . Улаанбаатар.

ЭМЯ-ны статистик мэдээ (2020) . Улаанбаатар.

ХАНСХЕТ 2020, Нутаг дэвсгэрийн түвшний хот байгуулалтын иж бүрэн үнэлгээ,
Монгол орны хот байгуулалтын байгалийн нөхцөл, Ц.Хоролжав, 2011

ХАНСХЕТ 2020, Уур амьсгалын үнэлгээ

ХАНСХЕТ 2020, Газар чичирхийллийн үнэлгээ

Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, 2020-2024

ХАНСХЕТ 2020, Инженер геологийн тайлан

ХАНСХЕТ 2020, Газрын гадаргын үнэлгээ

“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого

БОАЖЯ (2017). Монгол орны Байгаль орчны төлөв байдлын тайлан, 2017-2018 УБ.

ХАНСХЕТ 2020, Аялал жуулчлалын судалгаа

ХАНСХЕТ 2020, Цэвдэг хүйтний үзэгдэл, тархалтын үнэлгээ

ХАНСХЕТ 2020, Ус хангамжийн үнэлгээ

ХАНСХЕТ 2020, Эрчим хүчний судалгаа

ХАНСХЕТ 2020, Уул уурхайн салбарын хэтийн төлөв